*Сайтар эсэргүүцэж эс асуухад санаагаар хүний эрдмийг дэмий бүү цэнэ*
*Эрдэнийн сан Субашидаас*

МОНГОЛ УЛСЫН ЗГМ ШИЛДЭГ СОНИН

# ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.04.12, ПҮРЭВ ~ №075 (874) ~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~ ҮНЭ: 1000₮

**Ирээдүйг өөрчлөх эко бизнес**
Хог хаягдалгүй бизнес эрхлэгчид хэрэглэгчээ өөрсдөө бэлдэж байна. >5

FT FINANCIAL TIMES
Бизнес, эдийн засгийн төрөлжсөн суваг Financial Times-ийн нийтлэлүүдийг албан ёсны эрхтэйгээр хүргэж байна.

**Эдийн засаг эрсдэл дунд өндийнө**
ДНБ-ий өсөлт энэ онд саарч, ирэх онд нэмэгдэх таамаг гарлаа. > 11

ZGM DAILY
**ADB: Mongolia's economic recovery to continue**
Asian Development Bank releases Mongolia Economic Outlook 2018. > 7

## ОНЦЛОХ

### УЛС ТӨР
**С.Эрдэнэ Ерөнхий сайд асан** Ч.Сайханбилэгийг АН-аас хөөгөөгүй гэж мэдэгдэв.
**Монгол, Хятадын бизнес** форум Бээжин хотноо боллоо.
**Европын сэргээн босголт, хөгж-**лийн банкнаас $1.5 тэрбумын 96 төсөл хэрэгжүүлжээ.
**С.Баяр, Ч.Сайханбилэг нарыг** үргэлжлүүлэн хорих санал шүүхэд хүргүүлжээ.

### ЭДИЙН ЗАСАГ
**Монголын эдийн засаг энэ онд** 3.8 хувиар өсөх боломжтой гэв.
**Fitch агентлаг МАК-ийн** зээлжих зэрэглэлийг "CCC+" түвшинд баталгаажуулаа.
**БНХАУ банк, санхүүгийн** салбараа илүү нээлттэй болгохоор зорьж байна.
**Нийгэм, эдийн засгийн** гуравдугаар сарын үзүүлэлтийг өнөөдөр танилцуулна.
**ТОП-20 индекс 19234.93 нэгж** болж, 2.62 хувиар буурчээ.

**TOP-20 индекс**




### НИЙГЭМ
**БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр** Туул, Сэлбэ голын урсацыг сайжруулах ажил хийнэ.
**Нийслэлд 29 байршлын 134 га** газар дуудлагаар худалдана.
**Энэ өвөл, хавар улсын** хэмжээнд нэг сая мал хорогджээ.
**ОӨУБЕГ хуулийн этгээдийн** нэрийг цахимаар олгож эхэллээ.
**ЭЕШ-ын босго оноог 480** болголоо.

### ДЭЛХИЙ
**АНУ Сирид цохилт өгвөл** эмгэнэлт үр дүнд хүрч болзошгүйг Москва анхааруулав.
**ОУВС-гийн тэргүүн К.Лагард** улс орнууд протекционизмаас татгалзахыг уриалжээ.
**Хятадын гааль АНУ-аас ирсэн** 500 тонн хаягдлыг буцаахыг шаардсан байна.
**Москвагийн валютын бирж** дээр ам.доллар 62.37, евро 76.85 рублийн ханштай байв.
**Facebook хэрэглэгчдээ** аккаунтын аюулгүй байдлын талаар дохио илгээж эхэлжээ.

## ЦАГ АГААР

**УЛААНБААТАР**
2018.04.12

9° 2°

**БАГА ЗЭРГИЙН ХУР ТУНАДАС**

ЦАГ АГААРЫН ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

8 658000 029112 00874

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

# ХУДАЛДААНЫ ДАЙНЫГ ЭС ТООЦВОЛ ЮАНИЙН ХАНШ ТОГТВОРЖИНО

АНУ, БНХАУ-ын хооронд худалдааны дайн дэгдэж эхэлсэн нь ам.доллар, юанийн ханшид тодорхойгүй байдал дагуулж байна. Энэ эрсдэлийг эс тооцвол төгрөгтэй харьцах юанийн ханш дунд хугацаанд тогтвортой гэж шинжээчид таамаглаж байна. ▶ 12

С.Батсайхан / ЗГМ©

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН

## Үндэслэлгүй бий болсон хөрөнгийг хураадаг болъё

**Б.Энхжаргал**
@enkhjrglZGM

"Улаанбаатар төмөр зам" Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг нэхэмжлэл гарган, өмнөх дарга Л.Пүрэвбаатарын нийгэмлэгийн хөрөнгөнөөс өөртөө бариулсан тансаг хаусыг нь хурааж авч чадлаа. Лхагва гарагт болсон Нийслэлийн давж заалдах шатны шүүх хурлаас Л.Пүрэвбаатарын 1.5 тэрбум төгрөгөөр үнэлэгдэх, Зайсанд байрлах хаусыг нь хурааж авах шийдвэрийг гаргасан юм. Улмаар уг хаусыг дуудлага худалдаагаар зарж, орлогоор нь төмөр замчдыг орон сууцжуулахад зарцуулна" гэж "Улаанбаатар төмөр зам" ХНН-ээс мэдээлсэн юм.

АТГ-аас Төрийн өндөр албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг авдаг болоод нэлээн хэдэн жил өнгөрлөө. Монголд үндэслэлгүй мөнгөжсөн, эх үүсвэр нь тодорхойгүй үл хөдлөх хөрөнгөтэй болсон төрийн өндөр албан тушаалтнууд бий. Насаараа төрийн албанд ажиллаж байгаа, гэр бүл нь бизнесгүй, аль нэг компанид хувь, хувьцаа эзэмшдэггүй атлаа хадгаламж дахь мөнгөний хэмжээ, үл хөдлөх хөрөнгийнх нь үнэлгээ тэрбум тэрбумаар хэмжигддэг.

▶ 3

НИЙГЭМ

## Тариалалтад 60 мянган тонн буудайн үр шаардлагатай

**Г.Оюунтөгс**
@oyuntugsZGM

Хаврын дунд сар талдаа орж байна. Энэ улиралд хөдөө аж ахуйн, тэр дундаа газар тариалангийн салбарынхны гол ажил эхэлдэг. Улсын хэмжээнд хаврын тариалалтын бэлтгэл ажил ид өрнөж байна.

Энэ жил хагас сая гаруй га талбайд тариалалт хийхээр төлөвлөөд байна. Үүнээс 408.9 мянган га талбайд үр тариа, 390.4 мянган га-д улаан буудай, 15.5 мянган га-д төмс, 8.4 мянган га-д хүнсний ногоо, 32 мянган га-д тэжээлийн таримал, 41.9 мянган га-д тосны ургамал, 6.5 мянган га-д жимс жимсгэнэ тариалах аж. Харин ургац хураалтын хувьд 538.4 тонн үр тариа, 518.7 мянган тонн улаан буудай, 171.2 мянган тонн төмс, 101.9 мянган тонн хүнсний ногоо, 64 мянган тонн малын тэжээл, 34.2 мянган тонн тосны ургамал, гурван мянган тонн жимс, жимсгэнэ авахаар төлөвлөжээ.

▶ 6

ЗГМ: ИНФОГРАФИК

## ЗАСГИЙН ГАЗРУУДЫН ГАДААД ӨР




FT FINANCIAL TIMES

## АНУ-ын хориг Оросын компанийг дампууруулж магадгүй

**Хенри Фой**

Зургаан сарын өмнө Олег Дерипаска Лондоны хөрөнгийн бирж дээр Оросын хамгийн нэртэй, баян олигархын хувьд хүндрэлтэй арилжааг амжилттай хийж, баяр хөөр болж байв. Ноён Дерипаска хөнгөн цагаан олборлолт, усны эрчим хүч үйлдвэрлэлийг хамарсан EN+ компаниа 2014 оны Украйны хямралаас хойш Их Британид анх бүртгүүлж чадсан нь тэр юм. Гэвч өнгөрсөн долоо хоногт АНУ Оросын бизнес болон улс төрд хамааралтай хүмүүст хориг арга хэмжээ авсны улмаас тэр үед зориглосон хөрөнгө оруулагчид одоо алдагдал хүлээж магадгүй боллоо. Кремльтэй ойрын холбоотойн улмаас хоригт өртсөн ноён Дерипаскагийн хөрөнгө түргэн дундарч байгаа учир өндөр тушаалын найз нөхдөөсөө тусламж эрэх шаардлага тулгарав. Түүний компанийн захирлууд зөвлөлөө орхиж, хувьцааных нь үнэ унаж буйгаас зээлийн дефолт үүсэж болзошгүй байна.

▶ 9

| АЛТ | ЗЭС | 10-ЧИНГИС БОНД | ХУРАЛДАЙ БОНД | ГЭРЭГЭ БОНД | АМ.ДОЛЛАР | ЮАНЬ | РУБЛЬ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1343.57 | 6945 | 97.870 | 112.67 | 99.200 | 2392.76 | 386.83 | 37.50 |
| 0.29% | 1.68% | 0.06% | 0.06% | 0.08% | | | |

## Улс төр

# Г.Бямбалхам: Хүүхдийн мөнгийг 2019 онд нөхөж олгохгүй

Хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 80 хувьд олгосноор мөнгө авах хүүхдийн тоо 228 мянга орчим болно.

С.Батсайхан / ЗГМ©

### *Хүүхдийн мөнгө олгох хугацаа тодорхойгүй байна*

**З.Гэрэл**
ЗГМ

Улсын энэ оны төсөвт хүүхдүүдэд сар бүр олгодог 20 мянган төгрөгийн тэтгэмжид зориулан 164 тэрбум төгрөг тусгасан. Уг мөнгийг нийт хүүхдийн 60 хувьд олгох ёстой. Тэгвэл хүүхдийн мөнгөний хувийг өсгөх, хамрах хүрээг нэмэгдүүлэх тогтоолын төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Г.Занданшатар УИХ-ын дарга М.Энхболдод өргөн барьсан.

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хамрах хүрээг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай тогтоолын төсөлд Өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт хүүхдийн 80 хувьд олгохоор тусгасан юм.

0-18 хүртэлх насны хүүхдэд сар бүр амьжиргааны түвшний үнэлгээний 554 болон түүнээс доош оноотой өрхийн 684 мянган хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг төрөөс өгдөг. Төсөв батлах үеэр "Эдийн засгийн орчин хүнд байгаа учраас хүүхдүүдийн үлдсэн 40 хувьд мөнгийг нь 2019 онд нөхөж олгоно" хэмээн иргэдийн бухимдлыг намжааж байлаа.

Монгол хүүхэд бүрт төрийн хишиг ижил тэгш үйлчлэх ёстой. Хүүхдээ алагчлах хэрэггүй гэх эцэх эхчүүдийн цахим давалгаа төрийн бодлогод бага ч атугай нөлөөлж, нийт хүүхдийн 80 хувь нь "цалин" авахаар болсон нь сайшаалтай. Гэвч дахиад л тодорхойгүй хэд хэдэн асуулт олон нийтийн дунд байсаар байна.

Тухайлбал, өрхийн орлогын хувь хэмжээ ямар хэмжээнд байвал дундаж амьдралтай гэж үзэх, босго онооны хэмжээ нь хэд байвал авах нөхцөл үүсэх, 80 хувьд багтсан хүүхэд хэзээнээс мөнгө авах болон шугамын гадна үлдсэн хүүхдүүдэд 2019 онд мөнгө нөхөж олгох уу гэх мэт олон асуултад эцэг эхчүүд хариулт хүсэж байгаа юм. Тухайлбал, гурван хүүхэдтэй залуухан ээж "Хүүхдийн мөнгө авах шалгуурт тэнцээгүй. Айл л болсон хойно цахилгаан хэрэгсэлтэй. Лизингийн байртай, зээлээр машин авсан. Мөн аавын минь машин миний нэр дээр байдаг. Гэтэл зээлтэйг нь асуухгүй байж хоёр ч машинтай, орон сууцтай учраас хасагдсан гэсэн 60 хувьд багтаагаагүй. Одоо 80 хувьд олговол миний хүүхдүүд 20 мянган төгрөгөө авах уу.

Өнөөдрийн нийгэмд залуу гэр бүлүүдийн нийтлэг амьдрал зээлийн систем дээр босож байна. Бараг хүүхдүүдээсээ бусдыг зээлж байна шүү дээ" хэмээн хошигносон юм.

Эдгээр эргэлзээг арилгахаар Хөдөлмөр халамж үйлчилгээний ерөнхий газрын Хүүхдийн мөнгөн тэтгэмж хариуцсан мэргэжилтэн Г.Бямбалхамаас хариулт авлаа.

- **Мөнгөө аваагүй хүүхдүүдэд 2019 онд нөхөж олгохгүй. УИХ-ын 63 дугаар тогтоолоор зохицуулагдаж байгаа" гэв.**
- **Залуу гэр бүлүүдийн нийтлэг амьдрал зээлийн систем дээр босож байна.**
- **554 байсан босго оноог нэмэгдүүлсэн хэд хэдэн хувилбарыг гаргаж Засгийн газарт хүргүүлсэн байгаа.**

Тэрбээр, "Монгол Улсын нэг өрхийн дундаж орлого нэг сая төгрөг байна. Нийт өрхийн 72.3 хувь нь үүнээс доош орлоготой гэсэн судалгаа гарсан. Иймд ядуурлын түвшинд ойролцоо дундаж бүлгийн өрхөд чиглэсэн бодлого, хөтөлбөрийг нэмэгдүүлснээр тэднийг ядуурал өртөхөөс хамгаалах боломжтой.

Хүүхдийн мөнгийг нийт хүүхдийн 80 хувьд олговол мөнгө авах хүүхдийн тоо 228 мянга орчим болно. Засгийн газрын мэдээллээр 41 тэрбум төгрөг шаардлагатай. Манайх 554 байсан босго оноог нэмэгдүүлсэн хэд хэдэн хувилбарыг Засгийн газарт хүргүүлсэн. Одоогоор түвшин тодорхойлох оноог нэг мөр тогтоогүй байна. Мэдээж ойрын хугацаанд эцэслэгдэж, энэ сарын 20-ны өдөр гэхэд 80 хувьд багтсан хүүхдүүд мөнгөө авна. Мөнгөө аваагүй хүүхдүүдэд 2019 онд нөхөж олгохгүй. УИХ-ын 63 дугаар тогтоолоор зохицуулагдаж байгаа" гэв. [ЗГМ]

## ЗГМ ТОВЧХОН

**» ЗАРЛИГ**
Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай зарлиг гаргалаа. Зарлигийн хувийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга З.Энхболд Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн дарга Г.Баасанд гардуулан өгөв.

**» БАЙНГЫН ХОРОО**
9.7
Сая ам.доллар. Эдийн засгийн байнгын хороо өчигдөр хуралдлаа. Европын сэргээн босголт, хөгжлийн банкнаас "Улаанбаатар хотын хатуу хог хаягдлыг боловсруулах байгууламжийг шинэчлэх төсөл"-ийг хэрэгжүүлэхэд таван сая ам.долларын буцалтгүй тусламж, 9.7 сая ам.долларын зээлийн хөрөнгийг Монгол Улсын Засгийн газарт олгохоор тохирчээ. Зээлийн хугацаа 15 жил, зээлийн үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх хугацаа гурван жил болохыг С.Чинзориг сайд танилцууллаа.

**» МЭДЭЭЛЭЛ**
УИХ-ын гишүүн О.Баасанхүү өчигдөр мэдээлэл хийлээ. Тэрбээр "Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг шалгах Ажлын хэсэгт би багтсан. Монгол Улс төрийн тэргүүнээр ажиллаж байсан нөхдөд өргүй. Ялангуяа Н.Багабанди, Н.Энхбаяр нарт. Тиймээс Н.Багабандийг Оюутолгой компанийн ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх хэрэгтэй" гэв.

**ЭШЛЭЛ**

Ойрын өдрүүдэд АТГ-аас улс төрийн өндөр албан тушаалтнуудыг баривчлан хорьсон явдал олны анхаарлын төвд байна. Үүнд Ардчилсан намын хэд хэдэн лидер сэжигтнээр татагдан хоригдсон. Ерөнхий сайд асан Ч.Сайханбилэгийг АТГ-аас саатуулахтай зэрэгцэн түүнийг АН-аас хөөх шийдвэр гарсан гэх мэдээлэл цахим орчинд цацагдаад байна. Нэгдүгээрт, С.Баярцогт гэдэг хүнийг намаас хөөгөөгүй. Ардчилсан намын дүрэмд намаас хөөх ойлголт байхгүй. Тэр бол коммунист ойлголт. Харин Ардчилсан намын гишүүнчлэлээс хассан. Тодорхой хугацаатай үүрэг даалгавар өгсөн. Асуудлаа шийдтэл түүнийг намын гишүүнчлэлээс хассан. Харин Ч.Сайханбилэгийн хувьд асуудал өөр. Түүнийг ямар нэгэн байдлаар гэм буруутайг нь хууль, шүүхийн байгууллага тогтоож, нотлоогүй байна. Өөрөө ч ямар нэгэн тайлбар өгөөгүй байгаа. Тийм болохоор цахим орчноор шуугиад байгаа шиг тийм амар хөөхгүй, гишүүнчлэлээс нь хасахгүй. Харин ч хуулийн хүрээнд хэрхэн тусалж болох, улс төрийн зорилгоор хэлмэгдүүлэхгүйн тулд журмын нөхдийнх нь зүгээс тусалж дэмжинэ.

*УИХ-ын гишүүн, АН-ын дарга*
**С.Эрдэнэ:**

**АЙЛЧЛАЛ**

## Монгол, Хятадын бизнес эрхлэгчид 4.6 тэрбум ам.долларын гэрээ үзэглэлээ



Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх БНХАУ-д хийж буй айлчлал Бээжин хотноо үргэлжилж байна. Монгол, Хятад хоёр улсын улс төр, бизнесийн салбарынхан чуулж хөрөнгө оруулалт, хоёр орны хамтын ажиллагааны олон талт арга хэмжээний талаар ярилцлаа. Монгол, Хятадын бизнес форумын үеэр хоёр улсын бизнес эрхлэгчид 4.6 тэрбум ам.долларын санхүүжилт бүхий 36 гэрээ, хэлцэл байгуулсан.

Хоёр орны аж ахуйн нэгжүүд байгаль орчин, уул уурхай, усан хангамж, гэр хорооллын дахин төлөвлөлт, худалдаа, зочид буудал, барилга, мах, махан бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр, төмөр зам, эрчим хүч, банк, санхүү, аялал жуулчлал зэрэг чиглэлээр хамтран ажиллах юм. Тухайлбал, Бөөрөлжүүтийн дулааны цахилгааны станцийн төсөлд "Бодь Интернэшнл" ХХК, China State Consruction Engineering компанитай хамтран ажиллах 450 орчим сая ам.долларын өртөг бүхий гэрээнд гарын үсэг зурсан байна.

2017 оны эцсийн байдлаар хоёр орны гадаад худалдааны хэмжээ 6.7 тэрбум долларт хүрээд байгаа бөгөөд энэ нь өнгөрөгч оноос 36 хувиар өссөн үзүүлэлт аж. Тодруулбал, энэ нь Монгол Улсын нийт гадаад худалдааны 63 хувийг эзэлж байгаа гэнэ. Хоёр улс 2020 он гэхэд гадаад худалдааны хэмжээг 10 тэрбум ам.долларт хүргэх зорилтыг хамтран дэвшүүлснийг форумын үеэр Ерөнхий сайд онцолжээ.

Тус форумд МХАҮТ-ийн ерөнхийлөгч Б.Лхагважав оролцож хэлсэн үгэндээ "БНХАУ, Монгол Улсын хувьд хөрөнгө оруулалтын түнш байсаар байх болно. Энэ форумд Монголын талаас 299 бизнес эрхлэгчид оролцож байна. Энэ форум хоёр улсын эдийн засаг худалдааны эргэлтийг өргөтгөхөд чухал үүрэг гүйцэтгэх ёстой. Монгол, Хятадын компаниудын харилцаа шинэ түвшинд гарна гэдэгт итгэлтэй байна. Бизнес, хууль эрхзүйн орчин бүрдсэн байна. Харилцан ашигтай, хамтдаа хөгжихийг хүсье" гэжээ.

Хятадын олон улсын худалдааг дэмжих хорооны дарга Жян Зөнвэй хэлсэн үгэндээ "Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ёстой. Монгол Улсад үйлдвэржилтийн эрэлт хэрэгцээ их байгаа. Манай улс энэ чиглэлээр туршлагатай бөгөөд хамтран ажиллах боломжтой" гэлээ.

"Монгол Улс гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад ижил тэгш боломж олгож байгаа. Өөрөөр хэлбэл, ямарваа нэг байдлаар ялгаварлахгүй. Татварын бодлогоор ч дэмжинэ" гэж Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар онцлов.

Энэ удаагийн форумд хоёр улсын 600 гаруй бизнес эрхлэгч оролцож, хүнс, хөдөө аж ахуй, хил орчмын эдийн засгийн хамтын ажиллагаа, уул уурхай, хүнд үйлдвэр, дэд бүтэц, барилгын салбарын хамтын ажиллагааны сэдвээр харилцан санал солилцож байна. [ЗГМ]

**ШИЙДВЭР**

## С.Баяр, Ч.Сайханбилэг нарыг үргэлжлүүлэн хорих санал хүргүүлжээ

**Б.Энх**
ЗГМ

Нийслэлийн Прокурорын газраас өчигдөр Ерөнхий сайд асан С.Баяр, Ч.Сайханбилэг нарыг Авлигатай тэмцэх газраас баривчлан, шалгаж байгаатай холбоотой асуудлаар мэдээлэл хийлээ. Энэ сарын 10-ны орой АТГ нэр бүхий албан тушаалтныг баривчлан саатуулах арга хэмжээ авсан. Лхагва гарагт АТГ-аас Нийслэлийн прокурорын газарт дээрх хүмүүсийг яллагдагчаар татах санал ирүүлсэн байна. Уг саналыг Нийслэлийн прокурорын газар хүлээн авч, дээрх хүмүүсийг эрүүгийн хэрэгт татан үргэлжлүүлэн цагдан хорих саналыг Сүхбаатар дүүргийн шүүхэд хүргүүллээ. Эргэн сануулахад, "Оюутолгой" төслийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар, "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК, "Айвенхоу Майнз Лимитед", "Рио Тинто" Интернэшнл Холдингс Лимитед"-ийн хоорондох 2009 оны аравдугаар сарын 6-ны өдөр байгуулсан хөрөнгө оруулалтын гэрээ, хувь нийлүүлэгчдийн гэрээ, 2015 оны тавдугаар сарын 18-ны өдөр Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөг батлахад дээрх нэр бүхий албан тушаалтнууд албан тушаалаа урвуулан ашиглаж, илт хууль бус шийдвэр гарган бусдад давуу байдал үүсгэсэн байж болзошгүй хэмээн шалгаж буй. [ЗГМ]

**ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА**

Уншигч та манай сонины мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

› INFO@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

## Нийтлэлчийн булан

*АТГ албан тушаалтнуудын хөрөнгийнх нь эх үүсвэр юу байв гэдгийг тайлбарлуулдаггүй*

С.Батсайхан / ЗГМ©

# Үндэслэлгүй бий болсон хөрөнгийг хураадаг болъё

◀1

Гэвч АТГ албан тушаалтнуудыг өөртөө байгаа хөрөнгө, орлогоо үнэн бодитоор мэдүүлэхийг шаарддаг ч ийм их хөрөнгөтэй болох эх үүсвэр нь юу байв гэдэгт тайлбар авдаггүй. Олон нийт ч шаарддаггүй. Үүнийхээ оронд улстөрчид, төрийн өндөр албан тушаалтнуудыг "тэнгэрээс унаж ирсэн хөрөнгө"-өөр нь хэн нь илүү үнэтэй машин унаж, хэдэн компанид хувь эзэмшиж байгаагаар нь "хамгийн хамгийн" гэсэн утгагүй номинаци шалгаруулж, хэвлэлээр өргөмжлөн өөгшүүлж сууна.

Засгийн газрын хэвлэл мэдээллийн албанаас хоёр жилийн өмнө төрийн өндөр албан тушаалтнуудын цалингийн талаарх мэдээллийг гаргаж байв. Тухайн үед Ерөнхийлөгч сард 5.1 сая төгрөг авдгаараа Монголд хамгийн өндөр цалинтайд тооцогдож байлаа. Харин УИХ-ын дарга, Ерөнхий сайд 2.9 сая, УИХ болон Засгийн газрын гишүүн 2.1 сая, дэд сайдууд 1.9 сая, шүүгч, прокурор, АТГ-ын ажилтан, ҮХЦ-ийн гишүүн зэрэг албан тушаалтнууд 2.1 сая, хяналтын шатны шүүгчид 4.6 сая, аймаг нийслэлийн Засаг дарга нар 1.2 сая төгрөгийг тус тус авдаг талаарх мэдээллийг өгч байв. Цалингийн энэ систем Монгол Улсад одоо ч хэвээрээ үйлчилж буй.

Бараг хувийн компанийн хэлтсийн даргаас ч бага цалинтай байж гэнэт ихээр хөрөнгөжсөн албан тушаалтнууд хаанаас ийм их орлого олов? Энэ асуултад хариулж чадаагүй эхний хүн нь Л.Пүрэвбаатар болж байх шиг.

Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж хэдэн жилийн өмнө "хөрөнгөлөг хурандаа" гэсэн нэр томъёог бий болгож, цагдаагийн хурандаа нарын хөрөнгө, орлогын эх үүсвэрийг анхлан хөндөж байв. Төрийн нэр, албан тушаалаа ашиглаж баяжсан хурандаа нарт шүүмжлэлтэй хандан, цөөнгүй хурандаа нарыг албан тушаалаас нь чөлөөлж байсан. Тэгвэл одоо гурван сая төгрөгийн цалинтай шүүгчид яаж нэг тэрбумаас давсан үнэлгээтэй байранд амьдарч, сая ам.доллараар хэмжигдэх хадгаламжтай байгааг шалгуулъя. Бизнесгүй, хувьцаагүй, цалингаас өөр орлогогүй Их хурал, Засгийн газрын гишүүд, бусад албан тушаалтнуудаас ч хөрөнгийнх нь эх үүсвэрийг шаардъя.

УИХ-ын гишүүн Х.Нямбаатар шүүгчдийг хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарлахыг шаардаад буй. Дунджаар гурван сая төгрөгийн цалинтай шүүгчдийн дийлэнх нь Туул гол орчимд байрлалтай тансаг зэрэглэлийн орон сууцанд амьдарч байгаа талаарх баримтыг тэрбээр дэлгэсэн. Үйлдэл нь улс төрийн зорилготой эсэхийг мэдэхгүй ч Х.Нямбаатар гишүүний хэлж байгаа нь үнэн.

**Орлого, хөрөнгө хууль ёсных бол түүнийг нь ч гэсэн зарлаж, зөв ойлголт өгье**

Үнэхээр шүүгчдийн хөрөнгийн хөдөлгөөнийг шалгаж, олон түмний эргэлзээг тайлах цаг нь болсон. Хууль бусаар олсон орлогыг үл хөдлөх хөрөнгө болгож "зүсийг нь хувиргадаг" талаар улс төрийн хүрээнийхэн өөрсдөө ч ярьдаг. Эндээс харахад хөрөнгө орлогоо мэдүүлэх ёстойгоос бус, олж авсан арга замаа тайлбарлах үүрэг хүлээлгэдэггүй хуулийн цоорхой албан тушаалтнуудыг айж эмээхгүйгээр авлига авах боломжийг олгоод байгаа юм биш үү!!! Хэрэв тэр орлого, хөрөнгө хууль ёсных байвал түүнийг нь ч гэсэн зарлаж, олон нийтэд зөв ойлголт өгье. Энэ бүхнийг ажил болгоход бидэнд бэлэн туршлага бий.

Бусад улс орнууд үндэслэлгүй хөрөнгөжих байдалтай хэрхэн тэмцэж байна вэ? Их Британид өнгөрсөн сараас үйлчилж эхэлсэн шинэ хуулиар өндөр үнэтэй худалдан авсан хөрөнгийнхөө эх үүсвэрийг улстөрчид болон албан тушаалтнууд тайлбарлах үүрэг хүлээх болсон. Харин тайлбарлаж чадахгүй байвал хөрөнгийг нь хураах эрхийг хууль, хяналтын байгууллагууддаа олгосон байх юм.

Тус улсын Гэмт хэрэгтэй тэмцэх газрын мэдээлснээр, жил бүр авлигаас олсон 100 орчим тэрбум ам.доллар Лондон хотоор дамждаг аж. Энэ нь гол төлөв улсын төсвөөс завшсан мөнгө байдаг гэнэ. Өмнө нь, Их Британид үл хөдлөх хөрөнгө худалдан авч хууль бус мөнгөө нууж болдог байсан бол "Хууль бусаар хөрөнгөжих явдалтай тэмцэх тухай хууль" батлагдсанаар авлига авсан албан тушаалтнууд бултах аргагүй болж байгаа юм.

Өндөр үнэтэй бугуйн цаг зүүсэн Тайландын Шадар сайдын жишээг мөн дурдъя. Тус улсын Авлигын эсрэг хорооноос үнэтэй цагны хөрөнгийн эх үүсвэрийг шалгаж эхэлсэн нь Тайландад дуулиан дэгдээсэн. Улсынхаа Батлан хамгаалахын сайдаар давхар ажилладаг генерал Правит нь өнгөрсөн оны сүүлээр дор хаяж 2.5 сая тайн бат буюу 79 мянган ам.долларын үнэтэй Rolex, алмаасан шигтгээтэй бөгж зүүсэн явахдаа олон нийтийн хараанд өртөн, шүүмжлүүлж байв. Өөрийнхөө хөрөнгийн мэдүүлэгтээ дурдаагүй энэ үнэтэй цагийг ямар мөнгөөр худалдаж авсан талаарх тайлбар өгөхийг ард түмэн нь шаардахын зэрэгцээ өмнө нь 39.5 сая тайн баттай тэнцэх хэмжээний 25 төрлийн бугуйн цаг ээлжлэн зүүж байсан нь ч илэрсэн.

Манай урд хөрш БНХАУ авлигатай дайн зарлаад удаж буй. Энэ аяны хүрээнд албан тушаалтнууд дээд зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгийнхөө эх үүсвэрийг тайлбарлах шаардлагатай тулгарсан. Бүр авлигаар бий болгосон хөрөнгөө тайлбарлаж чадахгүй нь үнэтэй сууц, орд харш, зуслангуудаа хямд үнээр ч хамаагүй зарж, борлуулж эхэлсэн аж. Мэдээж авлигын хэргээр шалгагдаад нууц хөрөнгө зоорь нь илэрч, хэт баян нь мэдэгдэхээр илүү өндөр ял авна. Шанхай хотын үл хөдлөх хөрөнгийн худалдаа эрхлэгч "Shanghai Centaline Property Consultants" компанийн мэргэжилтэн улиралд 3-4 тансаг зэрэглэлийн байр зардаг байсан бол одоо сард л хоёрыг зардаг болсон талаараа хэвлэлд ярьжээ. Өндөр албаны дарга нар байшингаа хурдан борлуулж, хурдхан салахын түүс болж байгаа тул хямд үнээр ч хамаагүй өгөх болтлоо айсан аж. Энэ бол урд хөршийн удирдагчийн авлигатай тэмцэх ан авын үр дүнгийн нэг. Бусад улс орнууд энэ мэт аргаар албан тушаалтнуудыг үндэслэлгүй хөрөнгөжих боломжгүй болгож байгаа арга туршлагаас Монгол Улс ч гэсэн судалж, нутагшуулмаар байна. [ЗГМ]

**УХААРАЛ ХАЙРЛАХ УРАН ШОГ**

## Тайван эр



Херлуф Бидструп Уран шог

# Мөнгөний урсгал

# Жинхэнэ Трамп

*Аравдугаар сарын 6-ны өдөр АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Forbes сэтгүүлийн редактор Рэндалл Лейн, бүтээгдэхүүн хариуцсан захирал Льюис Д'Воркин нарыг хүлээн авч уулзан, санал бодлоо хуваалцсан юм. 50 минут үргэлжилсэн уг ярилцлагыг хураангуйлан танилцуулж байна. Ноён Ерөнхийлөгчийн ириаг ямар нэг засваргүйгээр танд хүргэж байна.*

**-Та аливаа бизнесийг удирдахдаа түүнээсээ таашаал авах нь хамгийн чухал гэж үргэлж ярьдаг. Одоогийн ажлаасаа таашаал авч байна уу?**

-Надад сайхан байна. Ажлаасаа таашаал авч байна. Их зүйл хийж амжууллаа. Хөрөнгийн бирж хамгийн өндөр үзүүлэлттэй байна. Ажилгүйдлийн үзүүлэлт сүүлийн 17 жилийн доод түвшинд хүрлээ. Үүнээс ч гайхалтай тоонууд биднийг хүлээж байна. Манай улс богино хугацаанд ч тэр, урт хугацаанд гайхалтай тоон үзүүлэлтүүд бий болгоно гэж бодож байна.

**-Таны философи юу вэ?**

-Би амжилтаар хөглөгддөг. Харин улс орны хувьд яривал бид мундаг амжилттай явж байна. Хойд Солонгос, Дундад Ази гэх мэт бага сага асуудал байна л даа. Би маш замбараагүй ажил хүлээж авсан. Үүнийгээ ч байнга хэлдэг. Бид Дундад Ази, Исламын улс зэрэг маш олон ээдрээтэй асуудалд ороолдсон байсан. Исламын улстай холбоотой есөн жил хийж амжаагүй их ажлыг бид есөн сарын дотор хийж гүйцэтгэлээ. Яг нарийн яривал найман жилийн ажлыг найман сарын дотор хийлээ. Бид үнэхээр хийж чадсан, хийсэн. Бид цэрэг армийн хувьд үнэхээр сайн ажиллалаа. Цэргийн ангийг нэмэгдүүлж байна. Бид саяхан 700 тэрбум ам.долларын төсөв боловсруулаа. Удахгүй батлагдана. Цэргийн хүч одоогийн нөхцөл байдлаас илүү шаардлагатай цаг үе бидэнд хэд хэдэн удаа тулгарч байсныг та нар мэднэ шүү дээ. Нэмж хэлэхэд энэ бол АНУ-д үй олон ажлын байр бүрдүүлэх өндөр ач холбогдолтой элемент юм.

**-Их ганцаарал, их ялалт давхацсан өдрөөс хойш нэг жил өнгөрчээ. Таны бизнесийн туршлага энэ ажилд тус нэмрээ үзүүлсэн үү. Та энэ ажилд бэлэн байсан уу?**

-Тусалсан гэж бодож байна. Үнэндээ энэ бол тэс ондоо ажил мэргэжил юм. Тал талын мэдлэг, чадвар шаардагддаг. Гэхдээ сонгуулийн кампанит ажил маань үнэхээр амжилттай болж өнгөрсөн. Хүмүүс намайг Хиллари Клинтоноос бага мөнгө зарцуулсныг мэддэггүй. Магадгүй энэ нь бизнесийн туршлагатай холбоотой байх. Тоон үзүүлэлтээр нь яривал хоёр өөр ертөнц л гэсэн үг. Дээр үед бага мөнгөөр ялалтад хүрэхийг амжилтад тооцдог байв. Харин өнөө үед энэ сэдвийг хэн ч сөхөхгүй байна.

Бид гараагаа амжилттай эхлүүлсэн гэж бодож байна. Өчигдөр орой би бүх генерал, адмирал нартай өндөр түвшний уулзалт хийж, оройн зоог барилаа. Та нар бараг мэдсэн биз. Уулзалт сайхан болж өнгөрсөн. Би тэдэнд "Танай тоног төхөөрөмж арай л өндөр үнээр хэтэрхий удаж ирж байна" гэж хэлсэн. Би тэдний бизнесийн харилцаанд, тухайлбал Lockheed-ээс F-35 байлдааны онгоц худалдан авахад нь тусалсан. Lockheed-ийн тэргүүнийг Мэрилин гэдэг байх аа. Үнэхээр мундаг хүн бий. Гэхдээ би Boeing, Lockheed нарыг хоорондоо нь өрсөлдүүлэх төлөвлөгөө боловсруулсан. Үүний ачаар Lockheed-ийн үнийг хэдэн тэрбум ам.долларааР бууруулж чадлаа. Гэтэл энэ бүхэнд би маш бага цаг зарцуулсан байх жишээтэй.

**-Ерөнхийлөгчийн хувиар эдийн засгийг сайжруулахад бизнесийн ертөнцөд тохиож байгаагүй ямар саад бэрхшээл тулгарч байгаа вэ?**

-Конгресс байна. Олон зүйл дээр том саад учруулж байна. Конгресст аливаа асуудалд хатуу байр суурь баримталдаг зөв хандлагатай хүмүүс бий. Тэд надад тээр болдоггүй. Гэтэл улс орны ашиг сонирхолд ямар ч ач холбогдолгүй зүйл хийхийг оролддог боло хийдэг суудал бөглөгчид байна. Би ийм л хүмүүстэй тэмцдэг.

Ямар ч Ерөнхийлөгчийн баталж амжаагүй олон хуулийг би өнгөрсөн есөн сарын дотор баталлаа. Бид одоогоор 50 хуулийн төсөл боловсруулаад байна. Тухайлбал, хэний ч баталж чадаагүй Ахмад дайчдын хариуцлагын хуулийг баталсан. Одоо бид татварын хууль дээр ажиллаж байна. Бас эрүүл мэндийн халамжийн асуудлыг цэгцэлнэ. Надад эрүүл мэндийн халамж дээр нэг санал дутуу байгаа. Гэхдээ авах л болно.

**-Шинэ шийдэлд хүртэл Obamacare-ийг үргэлжлүүлэх нь танай багийн үүрэг биш үү?**

-Тийм л дээ. Гэхдээ би Obamacare-ийг Обамагийн алдаа гэж үргэлж хэлдэг. Хэзээ ч бидний алдаа байгаагүй. Ардчилсан намынхан ямар нэгэн тохиролцоонд хүрэх гээд байх шиг байна. Гэтэл надад бас Бүгд Найрамдахчуудтай ярьж тохиорсон зүйл бий. Тиймээс аль алинд нь ашигтай байдлаар шийдэх хэрэгтэй. Бизнес энэ зарчмаар л явагддаг. Хэрэгтэй гэвэл би Ардчилсан намынхантай тохиролцоход бэлэн байна.

Надад бас хуулийн төсөл Эдийн засгийн хөгжлийн тухай бий. Гайхамшигтай хууль болно гэж үзэж байна. Хэн ч энэ талаар мэдэхгүй байгаа. Харин чи л хамгийн түрүүнд сонслоо. Би үүнийг хийх л болно.

**-Та энэ талаараа жаахан тодруулахгүй юу?**

-Компаниудад зориулсан эдийн засгийн хөгжлийн санаачилга. Компаниудыг эх оронд нь байлгах гэсэн бодлого. Компаниудыг ажил хийлгэх бодлого.

-Эх орноо орхисон компаниудад ноцтой шийтгэл хүлээлгэнэ гэсэн үг. Харин манай улсад үлдсэн компаниудыг урамшуулна. Хэрэв хилийн дээс давбал эргээд эх орондоо бүтээгдэхүүнээ худалдахад хэцүү болно гэвэл илүү ойлгомжтой байх.

**-Бизнесмэн хүний зүгээс харахад, хэрэв таны бизнесийн үйл ажиллагаанд төр оролцоод байвал ямар санагдах вэ. Үйл ажиллагаагаа хаана явуулах, хаана ажлын байр бий болгох вэ гэх мэт асуудал дээр?**

-Надад бол таалагдана. Учир нь чи энд үлдвэл татвар төлөхгүй. Бид компаниудаа хамгаалах хэрэгтэй. Эргээд харвал, компаниуд улс төрийн тэнэглэлээс, шуудхан хэлэхэд тэнэг улстөрчдөөс болж хохирсон. Тэд сүйрэлд орсон. Тиймээс тэднийг хамгаалах ёстой. Ажилчдаа хамгаалах ёстой. Үүнийг хуулиар л зохицуулна.

**-Хувь хүний татварын шинэчлэлийн хүрээнд зардал бууруулахгүй бол төсвийн алдагдал нэмэгдэнэ шүү дээ. Тэгсэн ч гэсэн та зардал бууруулахгүй гэж шийдсэн үү?**

-Юуны өмнө хэлэхэд, бид зардал бууруулна. Гэхдээ бидний хийж байгаа ихэнх зүйл ашиг авчирна гэдгийг хэлье. ДНБ-ийг аваад үзье. Өнгөрсөн улиралд ДНБ-ний өсөлт 3.1 хувь байсан. Энэ түвшинд мөддөө хүрч чадахгүй гэж бизнестэй маань холбоотой хүмүүс, ер нь хаа сайгүй ярьж байсан. Обама энэ тоонд хэзээ ч хүргээгүйг чи мэднэ дээ.

**-Татварын шинэчлэлийг хөндөхөд олон хүн "Трамп бол тийм ч хөрөнгөтэй хүн биш" гэж ярьдаг. Гэтэл таны хөрөнгө хэдэн тэрбумаар хэмжигдэг. Бид таныг хэдэн арван жил судалж ирсэн. Бүгд мэдэж байгаа. Хөрөнгийн татвар буюу нас барсны дараах татварыг хэлж байна.**

-Трамп тийм ч хөрөнгөтэй хүн биш гэв үү? Юу гэсэн бэ?

**-Хүмүүс тэгж ярьдаг. Харин бид Трампын хөрөнгийг хэдэн тэрбумаар үнэлдэг. Та өөрийнхөө хөрөнгийг бидний үнэлснээс илүү үнэлсэн шүү дээ. Гол нь одоогийн хэрэгжиж буй хөрөнгийн татвар цуцлагдах гэж байна. Энэ нь танд хэдэн тэрбумын ашигтай. Та үүнийг хэрхэн тайлбарлаж, америкчуудад "худалдах" гэж байна вэ?**

-Юу болохыг харах хэрэгтэй. Үл хөдлөх хөрөнгийн татварын улмаас гэр бүлийн олон компани бизнесээ худалдсан. Үүнд газар тариалангийн бизнес ч орно. Зөвхөн жижиг гэлтгүй маш олон салбар хамаардаг. Томоохон компаниуд ч мөн адил өндөр татвараас болж бизнесээ өчүүхэн үнээр худалдаж, алдагдалд орж байна. Ихэнх тохиолдолд уг бизнес гэр бүлийн эзэмшлээс гармагц үйл ажиллагаа нь доголддог. Хөрөнгийн татварын үндсэн зорилго энэ юм.

**-Тийм л дээ. Гэвч энэ улсаас төрсөн анхны бизнесмэн-Ерөнхийлөгчийн хувьд ганц заалт өөрчлөхөд л та болон таны гэр бүлд тэрбум гаруй ам.долларын өгөөж авчрах хуулийн төслийг хэрхэн дэмжүүлэх гэж байна вэ?**

-Эдийн засгийн өсөлт надад ашигтай. Энэ нь улс төрийн хувьд ч, нөгөө талаараа ч сайн хэрэг. Гэхдээ эдийн засаг гэдэг үнэхээр хачирхалтай юм, Рэндалл. Би агуу бизнес босгосон. Гэхдээ хүүхдүүд маань бизнесээ авч явж байна. Одоо надад хамаагүй болсон. Энэ талаар бодохоо ч больсон. Учир нь одоо миний хийж байгаа зүйл илүү том шүү дээ. Улс орон буруу зүгт явж байсан учир энэ бүхэн надад маш чухал байна. Миний хийж буй зүйл дундаж давхаргынханд эерэг нөлөө үзүүлж чадвал надад ч ашигтай тусна гэдгийг ойлго. Үүнтэй адил нийгмийн дээд давхаргынханд үзүүлэх нөлөө ч ижилхэн. Бидний ириад байгаа компаниуд олон хүний эзэмшилд байдаг. Чинээлэг хүмүүс ч эзэмшдэг, ядуу хүмүүс ч эзэмшдэг. Харин бизнесийн таатай орчин бүрдүүлж чадвал хүн бүхэнд ашиг тустай. Надад ч бас тустай.

## Компаниуд улс төрийн тэнэглэлээс, шуудхан хэлэхэд тэнэг улстөрчдөөс болж хохирсон

**-Түүхэн туршлага үүнийг боломжгүй гэдгийг баталсан шүү дээ.**

-Болж өнгөрсөн болон ирээдүйд болох зүйл гэвэл бид татварыг бууруулсан, цаашид өөрчилнө. Түүхэнд ямар ч Ерөнхийлөгчийн хийж чадаагүй хуулийн өөрчлөлт хийх болно. Миний хийсэн хуулийн өөрчлөлтийг мэднэ биз дээ. Ирэх долоо хоногт массаар нь өөрчлөх гэж байна. Би хууль дүрэмд итгэдэг. Маш үндэслэлтэй өөрчлөлтүүд байх болно. Хурдны зам барих гэж 21 жил зарцуулах ёсгүй биз дээ?

**-Та авьяасыг үргэлж чухалчилсаар ирсэн. Таны бүрдүүлсэн авьяастнууд улс орны хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг. Та Цагаан ордон, Засгийн газарт бүрдүүлсэн авьяаслаг багийнхандаа хэр сэтгэл хангалуун байгаа вэ?**

-Надад тал бүрийн авьяастан бий. Олон нийтэд танигдаагүй үнэхээр мундаг хүмүүс олон байгаа.

**-Эдгээрээс хамгийн амжилттай яваа нь хэн бэ?**

-Олон хүн байна. Хэн нэгнийг онцолмооргүй байна. Нэр дурдагдаагүй хүмүүсийн сэтгэл гонсойно шүү дээ.

**-Ямар хүн таны урмыг хугалсан бэ?**

-Ажлаас халах хүнээ хэзээ ч урьдчилж мэдэхгүй. Өмнөө суулгаж байгаад уулзахаас гадна тодорхой хүрээнд ажлын түүхтэй нь ч танилцаж болно. Энэ бүхнийг бизнестэй харьцуулж байсан эхний асуултаа санаарай. Одоо бол арай өндөр чадвар хэрэгтэй. Илүү зүрх сэтгэл хэрэгтэй. Учир нь эндээс гарах шийдвэрийг зөвхөн төсөв, түрийвч бус, хүний амьдралын сайн сайханд тулгуурлаж гаргадаг. Бизнесийн ертөнцөөс авьяас чадвар нь бүрдсэн олон хүн төрдөг. Гэхдээ нэмэлт чадвар хэрэгтэй. Улс төрийн чадвар хэрэгтэй байна.

**-Та Төрийн нарийн бичгийн дарга Р.Тиллерсонтой ямар харьцаатай байгаа вэ?**

-Тэр бол олон жилийн түүхтэй агуу компаниас гарч ирсэн хүн. Бидний үзэл бодол зөрчилддөг. Энэ бол байдаг л зүйл. Бид байр сууриндаа бат зогсох хэрэгтэй. Эцсийн дүнд миний үзэл бодол илүү нөлөөтэй. Амьдрал ийм л байна. Гэхдээ би түүнтэй сайн харилцаатай байдаг. Өөрөөр хэлбэл, бид хоёр бие биеэ ойлгодог.

**-Сүүлийн үеийн мэдээнээс сонсоход тэр таныг "тэнэг" гэсэн байсан. Энэ талаар тантай хувийн зүгээс уулзаж ярилцсан уу. Түүнийг үнэхээр тэгж хэлсэн гэж бодож байна уу?**

-Хэрэв тэгж хэлсэн нь үнэн бол надтай уулзах хэрэгтэй. Гэхдээ өөрийгөө тэгж хэлээгүй гэсэн л дээ. Төрийн департамент ч үүнийг үгүйсгэсэн. Би цуу яриа гэж бодож байна. Хэрэв үнэн бол бидний IQ тестийн хариуг харьцуулах болж дээ. Хэн ялахыг нь хэлээд өгч чадна шүү.

**-Та мөн өмнөх Ерөнхийлөгч нартай харьцуулбал шинээр маш цөөн томилгоо хийсэн. Бодлогын чанартай ингэж байна уу?**

-Яагаад гэвэл надад тийм олон хүний шаардлага байхгүй. Би бизнест ч энэ зарчмыг баримталдаг. Үүнийг тод томруунаар хэлж тайлбарласан боловч хэн ч дурдаж бичээгүй.

**-Тэгвэл та дахиж хэзээ ч томилгоо хийхгүй гэсэн үг үү?**

-Би тэгж их томилгоо хийхгүй. Учир нь бидэнд тийм олон хүн шаардлагагүй. Хэдэн зуун мянган ажилтантай энэ олон агентлагийг хар л даа. Ямар ч хэрэггүй. Би маш оновчтой хэдэн томилгоо хийсэн.

**-"Ярих хэрэг байна. Асуулт байна" гэх мэтээр залгаад ярьдаг хүн танд бий юү?**

-Надад найз нөхдийн хүрээлэл бий. Одоогийн байдлаар Вашингтонтой холбоотой хүрээлэл дунд байна. Эндхийн хүмүүстэй ихэвчлэн харьцаж байна. Их зөв асуулт байна. Найзуудтайгаа утсаар ярих дуртай боловч зав гардаггүй. Би бол хөдөлмөрч Ерөнхийлөгч. Би ажилдаа эрт ирдэг. Ажлаа маш эрт эхэлдэг. Өнөөдөр л гэхэд би Франц болон бусад орны удирдагчидтай ярьсан. Гэхдээ хамгийн ойр дотно байж чаддаг нь миний гэр бүл юм. Түүнчлэн бизнесийн холбоотой сайн найз нөхөд бий. Би бусдын санаа бодлыг сонсох дуртай. Би дэлхий дахинд болж буй үйл явдлын талаар мэдлэгтэй хүмүүстэй санал бодлоо хуваалцах дуртай.

**-Ганцаардах тохиолдол байдаг уу?**

-Миний ажил угаасаа л зоригтой, томоохон шийдвэр гаргахыг шаардаг ганц хүний албан тушаал юм. Хэрэв би онгоц худалдан авах бол хэдэн арван тэрбум ам.долларааР ярина. Гэхдээ онгоц худалдаж авах төдийхнөөр хэмжигдэхгүй. Хэдэн зуун тэрбум ам.долларын шийдвэр яригдана. Сирийн тухайд гаргасан шийдвэрээр тус улс руу 59 пуужин харвана гэж үзвэл энэ нь миний хувьд маш хүнд шийдвэр юм. Нэг бүр нь гайхамшигтай өндөр технологиор бүтээгдсэн, байгаа онодог пуужингууд бий. Тухайн үед би Флорида дахь Mar-A-Lago харшдаа БНХАУ-ын даргатай уулзаад амттан идээд сууж байсан. Гэхдээ энэ бол маш хүнд шийдвэр. Шийдвэрийг ганцаараа гаргах болдог. Манай цэрэг арми үнэхээр хүчирхэг. Богино хугацаанд улам хүчирхэгжсээр байна. Энэ бүх шийдвэрийг би ганцаараа л гаргадаг.

**-Таны бизнесийн туршлага энэ бүхэнд нөлөөлсөн үү?**

-Үгүй. Юу ч чамайг энэ бүхэнд бэлтгэж чадахгүй. Пуужин илгээх зэрэг асуудалд ямар ч туршлага нэмэр болохгүй. Хүний амь нас яригдана шүү дээ. Ийм зүйлд хэн ч бэлтгэгддэггүй.

**-Тэгвэл та Хойд Солонгосын асуудалд ямар байр суурьтай байна вэ. Та бүх л амьдралынхаа турш тохиролцож ирсэн. Гэтэл энэ асуудлаар зөвшилцөлд хүрэх орон зай үлдсэнгүй. Цаашид хэрхэх вэ?**

-Орон зай бага үлдсэн. Энэ асуудлыг өмнөх дөрөв, таван Засгийн газар аль хэдийнэ шийдэх ёстой байсан. Өнгөрсөн найман жилийн хугацаанд шийдчихэж болох байсан. Жил ирэх тусам улам хэцүүдэж байна. Ерөнхийлөгч Обама намайг Цагаан ордонд ирэхээс өмнө надтай яг энд суугаад ярилцахдаа үүнийг хамгийн хүнд шийдвэр гэж хэлсэн. Харин би түүнд "Чи юу ч хийгээгүй шүү дээ" гэж хэлсэн. Зүгээр л урсгалаар нь өнгөрөөчихсөн хэрэг. Тэр хүнд цөмийн зэвсэг ашиглахыг зөвшөөрөх ёсгүй байсан.

**-Сонгуулиар дамжуулан ОХУ манай хэрэгт хөндлөнгөөс оролцож байна хэмээн Дотоодын аюулгүй байдлын яамнаас 21 мужид хандаж мэдэгдсэн. Та ОХУ-ыг 2016 оны АНУ-ын сонгуульд оролцсон гэж үзэж байна уу?**

-Дотоодын аюулгүй байдлын яамнаас саналын тоонд өөрчлөлт ороогүй гэж мэдэгдсэн.

**-Би тооны өөрчлөлтийг бус, хөндлөнгөөс нөлөөлсөн эсэхийг асуусан юм.**

-Саналын үр дүнд ямар ч өөрчлөлт гараагүй гэж тэд хэлсэн. Ямар ч хуйвалдаан ороогүй гэдгийг ч бас хэлсэн. Сенатаас мэдэгдсэн. Ямар ч хуйвалдаан байхгүй. Надад ОХУ-ынхантай уулзаж, ярьсан зүйл байхгүй. Хүн бүхэн үүнийг Ардчилсан намаас хийсэн мэдэгдэл гэдгийг мэдэж байгаа. Ялах ёстой байтал ялагдал хүлээсэн гэж өөрсдийгөө дүгнэдэг Ардчилсан намынханд шалтаг хэрэгтэй байсан биз. Тэд 306:223-ын харьцаагаар ялагдсан байх аа?! Энэ бол зүгээр л Ардчилсан намынхан сонгуульд ялж чадаагүйгээ тайлбарлах гэсэн шалтаг.

**-Гэхдээ одоо нэгэнт суудал таных болчихсон хойно ОХУ сонгуулийн үр дүнд нөлөөлөхийг завдсан хэрэг таны санааг зовоож байна уу?**

-Хэрэв тэр нь үнэн бол маш том асуудал үүснэ. Миний санааг зовоосон том асуудал болно. Би эцсийн дүгнэлтийг нь хүлээж байна. Хариу нь удахгүй гарна гэж найдаж байна. Арга хэмжээ авах ёстой бол 2018 оны сонгуулиас өмнө авч амжина.

**-Та хэзээ ч хэн нэгний удирдлага дор ажиллаж үзээгүй. Гэтэл одоо та Америкийн ард түмэн гэх олон босстой болжээ. Энэ танд нөлөөлөх үү?**

-Би одоо 330 сая орчим босстой болсон. Гэхдээ удирдах арга барилд маань нөлөөлөхгүй. Учир нь миний шийдвэрүүд улс төрд нэр хүнд олохын тулд биш, зөв зүйл хийхийн төлөө байдаг. Би зөв зүйл хийх учраас надад нөлөөлөхгүй. Магадгүй улстөрч хүний зүгээс бус бизнесмэн хүний зүгээс харж болох юм. Гэхдээ улстөрч хүн улс төрийн хувьд ашигтай шийдвэр гаргана. Тиймээс би улсынхаа төлөө зөв зүйл хийх болно. Forbes


[ ЗГМ СОНИН ]

"Засгийн газрын мэдээ" сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилгоо болгоно.

ТУЗ-ийн дарга
**Эрдэнэбаатарын ДОЛГИОН**

Ерөнхий эрхлэгч
**Баатарын ДУЛАМХОРЛОО**

Зөвлөх
**Шатарбалын ДАВААДОРЖ**

Орлогч эрхлэгч
**Лхагважавын СУГАРМАА**
Утас: 99903584

**РЕДАКЦ**

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
**Эдитор Б.Энхжаргал**
Утас: 99901621

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба
**Эдитор Б.Баяртогтох**
Утас: 99901532

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
**Эдитор Г.Баярсайхан**
Утас: 99903574

**ЗАР СУРТАЛЧИЛГАА**

Утас: 99903581
99903578
99909472
99907843

**ХАЯГ**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
"Блю Скай тауэр" 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

**ЦАХИМ ХУВИЛБАР**
**ubinfo.mn**
**Дугаарын удирдагч**
З.Цэлмэг

8 658000 029112 00874

## Зах зээл

*Хог хаягдалгүй бизнес эрхлэгчид хэрэглэгчээ өөрсдөө бэлдэж байна*

**Б.Баяртогтох**
@bayartogtokhZGM

Дэлхий нийтийн өмнө хамтач эдийн засаг гэсэн ойлголт ихээхэн газар авч байгаа. Үүний тусгал нь хог хаягдалгүй бизнесийн хэтийн ирээдүйг улам тодотгох аж.

С.Батсайхан / ЗГМ©

# Ирээдүйг өөрчлөх эко бизнес

Хог хаягдалгүй бизнесийн зах зээл рүү гарааны компаниуд томчуудыг хошуучлан орж байна. Тэд эко хэрэглээг иргэдэд санал болгож, өөрсдөө органик бүтээгдэхүүн үйлдвэрлэх нөөц, боломж эрэлхийлэх болов. Тэрчлэн өрхийн орлогоо хэмнэх, өөр зүйлд мөнгөө зарцуулах, хэрэглээг илүү ухаалаг байлгахад анхаарч байна. Өөрөөр хэлбэл, өрхийн төсөв алдагдалгүй, өр зээл тэр хэрээр бага байх боломжтойг энэ бизнес давхар хэлэх аж.

Монголд шинэ тутам гэж хэлж болох уг төрлийн бизнест хөл тавьж буй компаниуд одоогоор гарын таван хуруунд багтахаар байгаа юм. Энэ бизнесийн онцлог нь хэрэглэгчээ өөрсдөө бэлдэж, тэдэнд нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг лангуун дээрээ өрөх явдал. Хэрэглэгч нэгэнт бий болсон бол тэнд зах зээл байна гэсэн үг. Компаниуд үүнийг хэдийнэ ойлгож, сургалт, зөвлөгөөг бизнесийн нэг хэсэг болгон авч явж байна. Монголд энэ төрлийн бизнесийн анхдагчийн нэг нь "Био амьдрал" дэлгүүр. Хэрэглэгчдэд танигдаж эхэлж буй тус дэлгүүр өөрсдийн гарын доорх материалаар дэлгүүрээ тохижуулдаг. Тэдний сайн санаачилга бусдад халдварлаж, хаягдал цаас хүртэл "амилж" байна.

Органик бараа худалдаа, сургалт, үйлчилгээний чиглэлээр ажилладаг тус дэлгүүр хог хаягдалгүй бизнесийг хөгжүүлж яваа гэж хэлж болно. Энэ бизнес нас залуу хэдий ч ирээдүйтэй гэдэгт олон хүн санал нэгддэг. Гэхдээ улсын хөгжлийн эрэмбэ, эдийн засгийн чадамж, хүмүүсийн сэтгэлгээ, хандлага голлох нөлөө үзүүлсэн хэвээр байна. Тухайлбал, гялгар уутгүй бүтээгдэхүүн борлуулдаг дэлгүүр Монголд тун цөөн. Хэрэглэгчийн сонголт гялгар уут болтлоо хэвшсэн. Бараг л дэлгүүр болгон гялгар уутны хэрэглээг дэмжиж, орчны бохирдол үүсгэж буй.

Гэтэл цаасан уут зөвхөн нэр төдий байсаар л. Гэхдээ энэ байдлыг халж байгаа дэлгүүрийн нэг нь "Био амьдрал". Тэднээс гадна "Жүр үр" компани гялгар уутнаас татгалзаж, өөрсдийн онцлог, давуу талаа тодотгосон цаасан уутаар үйлчилж эхэлсэн байна. Эко хэрэглээ тэлэх хэрээр Монголд цаасан уутны үйлдвэрлэл, түүний загвар хийц улам сайжрах, нэмэгдэх төлөвтэй. Бүтээгдэхүүний сав баглаа болгон хөрсөнд хурдан задардаг, дан ганц хүндээ эрүүл байгаад зогсохгүй хэрэглэсний дараа ч байгальд ээлтэй байх учиртайг хоггүй бизнес эрхлэгчид чухалчилж байна.

Дэлхийд жилд 2.1 тэрбум тонн хог хаягдал гардаг эдгээрийг хогны тээврийн машинд ачвал дэлхийг 24 удаа тойрсонтой тэнцэх урт цуваа үүснэ. Үүний гуравны нэгийг гялгар уут эзэлдэг гэсэн статистикийг The Economist саяхан нийтэлжээ. Харин энэ хэрэглээний есөн хувь л дахин боловсруулагддаг. Манай улсын хувьд ч ялгаагүй тулгарч буй бэрхшээлийн нэг нь гялгар уутны хэрэглээ. Иргэдийн сэтгэлгээг өөрчилж байж л энэ байдал өөрчлөгдөх шинжтэй. Хог хаягдалгүй бизнесийг хөгжүүлэгч компаниуд гялгар уутанд харш. Тэд хуванцар болон гялгар уутны хэрэглээг бууруулахад анхаарч, нийгмийн сүлжээнд манлайлан оролцож байна.

Бизнест ашиг хамгаас чухал. Гэхдээ хог хаягдалгүй бизнес эрхлэгчдэд эко хэрэглээ нэн тэргүүнд тавигдаж байна. Ийм бизнесийг тансаг хэрэглээнд огтхон ч хамаатуулж болохгүй юм. Гэтэл хүмүүс үүнийг тансаг хэрэглээ гэж тооцох нь бий. Энэ ойлголтоос л дээрх шинэ бизнесийн ирээдүй шалтгаална. Дэлхий нийтийн өмнө хамтач эдийн засаг гэсэн ойлголт ихээхэн газар авч байгаа. Үүний тусгал нь хог хаягдалгүй бизнесийн хэтийн ирээдүйг улам тодотгох аж. Дангаар эзэмших бус хуваалцах зорилготой эдийн засгийн шинэ дүрэм боловсорч байна гэсэн үг. Энэ үзэл санаа аанай л хүн төрөлхтний үйлдвэрлэдэг хаягдал бохирдлыг багасгах зорилготой. Бид хуванцар савны хэрэглээг худалдан авалтаараа дамжуулан хамгийн их тэтгэдэг. Гэтэл энэ нь байгаль орчинд заналхийлж, орчныг гүн бохирдуулсан хэвээр байна. Эл байдлыг өөрчлөхөд тийм ч хэцүү биш. Угаалгын бодис дууссан бол савыг нь хаях бус тэр савандаа л угаалгын шингээнээ арай хямд үнээр худалдан авах боломж байна. Үүнийг хог хаягдалгүй бизнес санал болгож байгаа юм. Цаана нь эко үйлдвэрлэл хөгжиж, үйлдвэрлэлийн зардал буурч, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь багасаж байгаа гэдгийг санах хэрэгтэй.

Тухайлбал, Монголын кофены зах зээлд хэдийнэ байр суурьтай эзэлж, хэрэглэгчийн танил болсон Caffe Bene хүрээлэн буй орчин төдийгүй хүний эрүүл мэнд аажмаар хор уршиг үзүүлэх хуванцрын хэрэглээг бууруулахад нэгджээ. Та тус газраар үйлчлүүлэхдээ өөрийн аягатайгаа очвол кофегоо 500 төгрөгийн хөнгөлөлттэй авах боломжтой аж. Гэхдээ тус байгууллага өнгөрсөн сарын 20-ноос энэ сарын 13-ныг дуустал дээрх хөнгөлөлт олгож байна. Хог хаягдалгүй бизнес хүмүүсийн хандлагыг өөрчилж, тэр хэрээр хэмнэлт хийх боломж, бололцоо бидний эргэн тойронд байгааг тод харуулна. Энэ утгаараа Монголын нөхцөлд ч уг бизнес илүү хөгжих боломжтой.

Хог хаягдалгүй бизнес дэлхий нийтэд хоол, хүнс, ариутгалын бодис, хувцасны зах зээлд түлхүү хамаарч байна. Жишээ нь, хоолны хаягдлын хувьд дээрх бизнес ашигтай ажиллахад онцгой хөшүүрэг болж буй. Дэлхий дээр жил бүр 1.3 тэрбум тонн хүнс хаягдаг гэсэн мэдээлэл бий. Энэ нь манай гараг дээрх газар тариалан эрхэлж буй нийт талбайн 30 хувьд ургуулсан хүнстэй тэнцэнэ гэхээр хэр их болох нь төсөөлөгдөх болов уу. Кофены шаар ашиглан мөөг ургуулж байна. Хоолны үлдэгдлийг цэцэрлэгжүүлэлтийн бүтээгдэхүүн болгон хувиргах шинэ арга туршиж эхэллээ. Зоогийн газар болон дэлгүүрт хаягдсан хүнсийг цуглуулан дахин боловсруулаад органик бордоо үйлдвэрлэх санааг аль хэдийнэ сэдсэн байна. Манай улсад энэ төрлийн бизнес хөгжих боломжтой. Тухайлбал, уул уурхайн томоохон төсөл хэрэгжиж буй уурхайн бүсэд хоолны хаягдал хамгийн их гарч байна. Ирээдүйг өөрчлөх эко бизнес АНУ болон Европт ашигтай бизнес болж, хөрөнгө оруулагчдын анхаарал өртөх болсон. Харин Монголд уг бизнесийг санаачилж буй компаниудад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт юуны өмнө үгүйлэгдэж байна. Тэд дунд хугацаанд илүү ахисан шатанд үйл ажиллагаа явуулна гэдэгтэй тун итгэлтэй байна.

Дэлхий нийтийн өмнө тулгарч буй уур амьсгалын өөрчлөлт, үүнийг дагасан сорилт, хүндрэл хүмүүсийн амьдралын хэвшилд онцгой нөлөө үзүүлж буй. Энэ нь бизнесийн шинэ санаа сэдэл болж, эко үйлдвэрлэлээс халиад хүмүүс эко хэрэглээнд алгуур шилжихэд хүргэж байна. Бидний өдөр тутмын хэрэгцээ болсон бараа, бүтээгдэхүүн илүү энгийн сав баглаатай болж, эдийн засгийн хувьд хэмнэлт дагуулахуйц шинэ соёл дадал болон сууж эхэлсэн. Гял цал гэхээс илүү эдэлгээ даах, эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд ээлтэй байх ёстой гэсэн зарчим энд түлхүү үйлчлэх болов. Тэгвэл яг ийм жишээг онцолсон, био амьдралын хэрэглээ, ач холбогдлыг таниулсан сургалт, зөвлөгөө цахим ертөнцөөр тархаж, энэ чиглэлийн мэдээлэл улам эрчээ авч буй. Уг мэдээллийн цаана хог хаягдалгүй бизнес дэлхий нийтэд хэр үнэ цэнэтэй болох, компанийн нэр хүнд, орлого ашиг нийгмийн хариуцлагаар хэмжигдэж буйг анзаарахгүй өнгөрч болохгүй нь. [ЗГМ]

- **Хог хаягдалгүй бизнесийн зах зээл рүү гарааны компаниуд томчуудыг хошуучлан орж байна.**
- **Монголд шинэ тутам гэж хэлж болох уг төрлийн бизнест хөл тавьж буй компаниуд одоогоор гарын таван хуруунд багтахаар байгаа юм.**
- **Эко хэрэглээ тэлэх хэрээр Монголд цаасан уутны үйлдвэрлэл, түүний загвар хийц улам сайжрах, нэмэгдэх төлөвтэй.**

### НЭГ УДААГИЙН ХУВАНЦРААС ТАТГАЛЗАХЫН ТУЛД

- Соруулнаас татгалзах
- Нэг удаагийн усны савнаас татгалзаж, байнгын хэрэглэдэг савтай болох
- Аль болох хуванцар материал ороогүй бүтээгдэхүүн худалдаж авах
- Өөрт байгаа хуванцар савнуудыг дахин хэрэглэх
- Худалдан авалт хийхдээ даавуун уут хэрэглэх
- Өөрийн хоолны савыг байнга авч явах

## Нийгэм

ГАЗАР ТАРИАЛАН

# Тариалалтад 60 мянган тонн буудайн үр шаардлагатай

***Тариалалтад шаардлагатай техник хэрэгслийн засвар 80 хувьтай байна***

С.Батсайхан / ЗГМ©

Зургаан аймгийн 12 суманд тариалалт хийхэд цаг агаарын таатай нөхцөл бүрдээгүй байна.

◄1

Үр тариа, тос, тэжээлийн ургамлын тариалалтыг 14 аймгийн 1480 гаруй аж ахуйн нэгж, иргэн гардан гүйцэтгэнэ. Харин төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн тариалалтыг 370 гаруй аж ахуйн нэгж, хоршоо, 35 мянган өрхийн хэмжээнд тариалахаар бэлтгэлээ хангаад буй. Мөн "Атрын III" аяныг үргэлжлүүлэхээр болсон байна.

Одоогийн байдлаар хаврын тариалалтад 3200 гаруй трактор, 2200 үрлүүр болон хөрс боловсруулах техник ажиллуулахаар төлөвлөсөн бөгөөд тэдгээрийн засварын ажил 80 хувьтай үргэлжилж байна. Энэ хаврын тариалалтад нийт 60 мянган тонн буудайн үр шаардлагатай. Аж ахуйн нэгжүүд өнгөрсөн оны ургацаас 24 мянган тонныг нөөцөлсөн бол Тариалан эрхлэлтийг дэмжих санд 25.8 мянган тонн, ОБЕГ-ын Улсын үрийн нөөцийн салбарт гурван мянган тонн гээд нийт 52.8 мянган тонн үрийн нөөц бүрджээ.

Үр тариаг хугацаандаа багтаан суулгахгүй бол ургац оройтох эрсдэлтэй. Ялангуяа, улаан буудайн үрийг тавдугаар сарын эхээр суулгах ёстой бөгөөд хожимдвол буудайн болц оройтохыг тариаланчид сануулж буй. Гэхдээ цаг агаарын төлөв байдлаас шалтгаалан түр хойшлогдох тохиолдол гардаг. Учир нь улаанбуудайн үрийг хүйтэнд суулгавал соёолдоггүй байна.

Сүүлийн жилүүдэд хаврын тариалалт эхлэх үед хур тунадасны хэмжээ 5.6-12.4 хувиар буурч, ууршилт 3-4 дахин нэмэгдсэн. Цаашид ууршилтын хэмжээ 7-10 дахин нэмэгдэх төлөвтэй байгаа юм.

Өнгөрсөн жилүүдэд гэхэд зуны улиралд агаарт 31-40, хөрсөн дээр 46-68.2 хэм хүрч халсан. Энэ бол үр тариа ургах тохиромжтой температураас 5-14 хэмээр илүү гэсэн үг. Агаарт 30 хэмээс дээш халсан өдрийн тоо 15-22 хоног үргэлжилснээс болж ургац 30-50, зарим жилд 65-70 хувиар буурсан байгаа юм. Энэ мэтчилэн Монгол орны уур амьсгал хувьсан өөрчлөгдөж байгаа нь буудайн ургалтын эхэн үед төдий л нөлөөлөхгүй ч цэцэглэлт, үр цутгалтын үед олон хоног үргэлжлэн халах нь ургац огцом буурахад нөлөөлөх эрсдэлтэй. Иймд хөрсний чийгийн нөөц, хангамжийг нэмэгдүүлэх гол эх үүсвэр болох хур тунадасыг хөрсөнд бүрэн шингээж хуримтлуулах, эрдэс бодис, шим бордоог системтэй хэрэглэх замаар хөрсний үржил шимийг сайжруулах зайлшгүй шаардлагатай байгаа аж.

ШУА-ийн Ургамал, газар тариалангийн хүрээлэнгийн Газар тариалангийн секторын эрхлэгч, доктор Ж.Намбар "Сүүлийн жилүүдэд уриншаа чанаргүй боловсруулсан, үр сортын бодлого алдагдсан, тариалах агро технологийн доголдол, хөрсний үржил шим буурч байгаагаас ургацын хэмжээ болон чанар буурсаар байна. Улсын хэмжээнд хийсэн шинжилгээний дүнгээр нийт 579.3 мянган га талбайн хөрсний 76.3 хувь нь 2.5 хувиас бага ялзмагтай, ургамалд хурдан ашиглагдах шим тэжээлийн бодисын хангамж 50 гаруй хувиар доогуур байгаа юм.

Тухайлбал, тогтвортой ургац авахад шаардагдах нитратын азотын агууламжаар нийт талбайн 59.7, фосфороор 42.3, калигаар 88.5 хувь нь дутагдаж байгаа нь манай тариалангийн хөрс хүнээр зүйрлэвэл өлсгөлөнд байгааг харуулж байна. Одоогийн байдлаар ирэх саруудын цаг агаарын төлөв албан ёсоор гараагүй боловч тав, зургадугаар сард олон жилийн дунджийн орчим хур тунадастай байна. Гэхдээ цаг агаар халж мэдэхээр байгаа тул тариаланчид ган болно гэж урьдчилан тооцож, тариалах технологио талбай бүрээр боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай" гэв.

Цаг уурын үзүүлэлтээс харахад ирэх сард дунджаар 5-14 хэмийн дулаан, хур тунадас олон жилийн дунджийн орчим орох төлөвтэй. Харин зургадугаар сард 25 хэм хүртэл дулаарч, хур тунадас ихэнх нутгаар 8-28 мм, зарим нутгаар 29-46 мм орох төлөв гарчээ.

Уриншилсан талбайн ашигтай чийгийн нөөц Булганы Тэшиг, Дорнодын Халх гол, Сэлэнгийн Ерөө, Баруунбүрэн, Номгон, Алтанбулаг, Хушаат, Төв аймгийн Жаргалант, Хөвсгөлийн Эрдэнэбулганд хангалттай. Харин Архангайн Түвшрүүлэх, Булганы Хутаг-Өндөр, Сэлэнгэ, Сэлэнгийн Зэлтэр, Цагааннуур, Орхон, Зүүнбүрэн, Дархан-Уул аймгийн дөрөв, тавдугаар бригад, Алтангадас, Цайдам, Төвийн Баянчандмань, Хөвсгөлийн Тариаланд хөрсний чийгийн хэмжээ дундаж үзүүлэлттэй байна. Түүнчлэн Булганы Бүрэгхангай, Өвөрхангайн Хархорин, Сэлэнгийн Баруунхараа, Зүүнхараа, Төвийн Угтаалцайдам, Эрдэнэсант, Борнуур, Цээл, Хэнтийн Хурх, Биндэр, Яргайт, Орхоны Улаантолгойд хаврын тариалалт хийхэд цаг агаарын таатай нөхцөл бүрдээгүй байна. [ЗГМ]

- **Улсын хэмжээнд 52,8 мянган тонн үрийн нөөц бүрджээ.**
- **Жилийн энэ үед хур тунадасны хэмжээ 5.6-12.4 хувиар буурч, ууршилт 3-4 дахин нэмэгддэг болжээ.**
- **Хаврын тариалалтад 3200 гаруй трактор, 2200 үрлүүр болон хөрс боловсруулах техник ажиллуулна.**

ҮЙЛЧИЛГЭЭ

## Хуулийн этгээдийн нэрийг цахимаар олгож эхэллээ

Хуулийн этгээдийн оноосон нэрийг цахимаар бүртгэх, баталгаажуулах үйлчилгээг ОӨУБЕГ үзүүлж эхэллээ. Тус байгууллагын http://les.burtgel.gov.mn цахим хаягаар холбогдон компани, аж ахуйн нэгжийн нэрсийг шүүж, боломжит хувилбараа илгээн, баталгаажуулах юм байна. Харин баталгаажсан нэрээ ажлын 10, хуанлийн 14 өдөрт багтаан хуулийн этгээдээр бүртгүүлэх аж.

Нэг иргэн өдөрт гурав хүртэлх оноосон нэр баталгаажуулах эрхтэй. Иргэд сонгосон нэрийнхээ түлхүүр үгээр хайлт хийж, ижил төстэй бусад нэрсийг шууд харах боломж бүрджээ.

Хуулийн этгээдийн нэрийг цахимаар олгосноор зөвхөн нэр авахын тулд бүртгэлийн байгууллагыг зорих шаардлагагүй болж байгаа юм. Албаны эх сурвалжийн мэдээлж буйгаар өдөрт дунджаар 100-200, жилд 20-40 мянган иргэн зөвхөн оноосон нэр авахын тулд 100 айл дахь тус төвийг зорьдог байна. Одоогийн байдлаар улсын бүртгэлийн мэдээллийн санд нийт 200 мянга гаруй хуулийн этгээдийн оноосон нэр бүртгэлтэй байдаг аж. [ЗГМ]

FISCAL

"ФИСКАЛ АУДИТ" ХХК

ХАРААГ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"БАЯНГОЛ ЭРЧИД БУУДАЛ" ХХ-ний 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдлын тайлан, түүнтэй өдрөөр тооцогдох болсон үүсгэлтэй орлогын тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон эх хөрөнгөөс өмчлөгч эзэмшлийн өөрчлөлтийн тайлан бүхэлдээ хавсаргасан санхүүгийн тайланд хяналт шинжилгээ хийсэн бөгөөд санхүүгийн тайланд тэмдэг тавьсан бүрэн санхүүгийн тайланд хуулж хавсаргав.

Аудитын дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитыг олон улсын Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэв. Эдгээр стандартын дагуу аудит нарийвчлалтай мөн тайлангийн Санхүүгийн тайлангийн Аудитад хүлээн хүлээгдэхгүй гэсэн хэсэгт заагдсан. Бид санхүүгийн тайлангийн аудитай холбогдсон мэдээ, нотлох баримтыг хангалтай, зохистой гэж үзсэн. Бидний олж авсан аудитын нотлогоо нь бидний гаргасан дүгнэлтэд шаардлагатай бүрэн хангалтай гэж үзсэн болно гэдэг нотлогоо байна.

Аудитын гол асуудалуд

Бидний нарийвчлалтай шаардлагатай гэж тайлбарлах гол асуудлуудыг эдгээр санхүүгийн тайлангийн аудитын явцыг бидний бодлоор гол асуудлуудтай холбоотой гэж үзсэн. Санхүүгийн тайлангийн аудитыг бид Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангуудыг материалаг нарийвчлалтай хэмжсэнтэй холбогдсон дотоод хяналтыг тооцоолж, нарийвчлуулсан мөрөн, нотлох баримт, гүйцэтгэл болон нарийвчлалтай дагаж мөрдөхийг бидэнтэй зөвлөдөг.

Аудитын үед санхүүгийн тайлангуудыг дахин дүн шинжилж болох тодорхойлох гол асуудлыг нотлогоо олж авахыг чиглэсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудитыг хийхдээ гүйцэтгэн санхүүгийн бичиг үүсэх зайлшгүй аудитыг материалаг бурууг илрүүлэхийн тулд хийсэн. Түүнчлэн санхүүгийн тайлангийн нарийвчлалтай холбоотой дотоод хяналтыг ойлгох гол гол, гүйцэтгэл болон нарийвчлалтай ойлгох зорилгоор бидэнтэй зөвлөдөг.

Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын зорилого

Бидний гүйцэтгэсэн аудитын явцыг гүйцэтгэхдээ эдгээр санхүүгийн тайлангуудыг аудитыг гаргах явцыг нь. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангуудыг материалаг нарийвчлалтай хэмжсэнтэй гэсэн ойлгох нотлогоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон нарийвчлалтай дагаж мөрдөхийг бидэнтэй зөвлөдөг.

Аудитын явц санхүүгийн тайлангуудыг дахин дүн шинжилж болох тодорхойлох талаар аудитыг нотлогоо олж авахыг чиглэсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын мэдээлэл гүйцэтгэн санхүүгийн бичиг үүсэх зайлшгүй аудитыг материалаг бурууг илрүүлэхийн тулд хийсэн. Түүнчлэн санхүүгийн тайлангийн нарийвчлалтай холбоотой дотоод хяналтыг ойлгох гол гол, гүйцэтгэл болон нарийвчлалтай ойлгох зорилгоор бидэнтэй зөвлөдөг.

Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын зорилого

Бидний гүйцэтгэсэн аудитын явцыг гүйцэтгэхдээ эдгээр санхүүгийн тайлангуудыг аудитыг гаргах явцыг нь. Бид Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангуудыг материалаг нарийвчлалтай хэмжсэнтэй гэсэн ойлгох нотлогоо олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх болон нарийвчлалтай дагаж мөрдөхийг бидэнтэй зөвлөдөг.

Аудитын явц санхүүгийн тайлангуудыг дахин дүн шинжилж болох тодорхойлох талаар аудитыг нотлогоо олж авахыг чиглэсэн горимуудыг гүйцэтгэсэн. Эдгээр горимуудыг аудиторын мэдээлэл гүйцэтгэн санхүүгийн бичиг үүсэх зайлшгүй аудитыг материалаг бурууг илрүүлэхийн тулд хийсэн. Түүнчлэн санхүүгийн тайлангийн нарийвчлалтай холбоотой дотоод хяналтыг ойлгох гол гол, гүйцэтгэл болон нарийвчлалтай ойлгох зорилгоор бидэнтэй зөвлөдөг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайлан Монгол Улсын "Компаний тухай хууль"-ийн 5-р зүйлд заасан нөхцөлийг хангаж "БАЯНГОЛ ЭРЧИД БУУДАЛ" ХХ-ийн гүйцэтгэхдээ зорилгоор бичгээсэн. Бид энэхүү тайлангийн аудитын явцад өөр асуудал гарсан бол гүйцэтгэсэн зорилгоор гаргасан.

ЗАХИРАЛ Б.ЭРДЭНЭБАЯР ДАЛТАНТӨГС

FISCAL AUDIT LLC

FISCAL

ОР ТОЛБОР БА ҮЛДЭГДЭЛ ОНОО

| | 2016-12-31 | 2017-12-31 |
|---|---|---|
| Дансны нэгж | | |
| Цэвэр борлуулалтын орлого | 44 495 517,06 | 40 888 465,66 |
| Борлуулалтын өртөг | (14 759 425,30) | (14 332 421,22) |
| Нийт ашиг | 4 195 363,47 | 94 275,67 |
| Бизнесийн бусад үндсэн ажлаас олсон орлого | 5 557 132 000,16 | 5 557 132 000,16 |
| Хүүгийн орлого | | |
| Нийгэмд ашгийн нөлөө | 193 822 953,32 | 345 312 453,82 |
| Үндсэлсэн орлого гарсан | | |
| Нийт өр төлбөр | | |
| Бусад богино хугацаат өр төлбөр | 3 318 772,28 | 3 478 507,28 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй бусад зорилгоор эзэмшиж өр төлбөр | | |
| Богино хугацаат өр төлбөрийн дүн | 4 294 813 578,78 | 4 302 633 643,25 |
| Урт хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат зээл | | |
| Нийт өр төлбөр | | |
| Хойшлуулсан татварын өр | | |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | |
| Урт хугацаат өр төлбөрийн дүн | | |
| Нийт өр төлбөрийн дүн | 4 294 813 578,78 | 4 302 633 643,25 |
| Эзэмшлийн хөрөнгө | | |
| Нийт хөрөнгө / хөрөнгө / | 34 998 030,00 | 34 998 030,00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц | (67 212 874,70) | (67 212 874,70) |
| Гадаад валютын хөрөнгөтэй нийлэх | (102 280 425,00) | (102 280 425,00) |
| Эзэмшлийн хөрөнгө | | |
| Хуримтлагдсан ашиг / алдагдал / | 26 395 779 727,61 | 28 741 489 086,79 |
| Эзэмшлийн нийт дүн | 26 405 436 927,91 | 28 816 865 207,09 |
| ОР ТОЛБОР БА ҮЛДЭГДЭЛ ОНОО | 32 700 450 506,71 | 35 134 190 930,34 |

FISCAL

ХОРОГДОГ

| | 2016-12-31 | 2017-12-31 |
|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгө | | |
| Эдийн бус бус хөрөнгө | 12 340 272 109,20 | 9 036 697 346,20 |
| Дансны мөнгө | 244 990 977,41 | 386 927 361,47 |
| Татвар, НДШ-ийн авлага | 310 008,00 | 3 145 545,72 |
| Бусад мөнгө | 10 063 521 750,13 | 18 036 725 842,13 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | | |
| Бараа материал | 1 070 224 962,59 | 987 147 286,14 |
| Урьдчилгаа төлсөн зардалтнууд | | |
| Бусад эргэлтийн хөрөнгө | | |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бусад зорилгоор) | | |
| Эргэлтийн хөрөнгийн дүн | 25 671 520 801,43 | 28 446 252 581,99 |
| Эргэлтийн бус хөрөнгө | | |
| Үндсэн хөрөнгө | 4 521 512 186,07 | 4 106 447 831,44 |
| Биет бус хөрөнгө | | |
| Борлуулах зорилгоор | | |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 2 587 377 317,26 | 2 587 377 317,00 |
| Хайгуулд ба үнэлгээний хөрөнгө | | |
| Хойшлуулсан татварын хөрөнгө | | |
| Хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмшиж буй үл хөдлөх эд хөрөнгө | | |
| Бусад эргэлтийн бус хөрөнгө | | |
| Эргэлтийн бус хөрөнгийн дүн | 7 108 929 503,33 | 6 693 825 148,44 |
| НИЙТ ХӨРӨНГӨЙН ДҮН | 32 780 450 506,76 | 35 134 190 930,43 |

FISCAL AUDIT LLC

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

*Огноо : 2018.04.12*

**Тендер шалгаруулалтын нэр:** Шугамаар ус хангах албаны ус түгээх байр буулгаж шинээр барих ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах.

**Тендер шалгаруулалтын дугаар/гэрээний дугаар:** УСУГ-АУ-2018-82

Ус сувгийн удирдах газар эрх бүхий тендерт оролцогчдоос **Шугамаар ус хангах албаны ус түгээх байр буулгаж шинээр барих ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах** цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тухайн тендерт эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр **50,000 /тавин мянган/** төгрөгний цахим тендерийн хураамж төлж оролцоно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

- Сүүлийн 2 жил буюу 2016, 2017 онуудын Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлнэ.
- Сүүлийн 2 жилд буюу 2016, 2017 онуудад ижил төстэй гэрээ хийсэн тухай мэдээлэл ирүүлнэ.
- Борлуулалтын орлого нь сүүлийн 2 жил /2016, 2017/ тус бүр тухайн ажлын төсөвт өртөгөөс дээш байх.
- Тендерийн хамт 3,000,000 /гурван сая/ төгрөгийн тендерийн баталгаа ирүүлнэ.
- Хүчинтэй байх хугацаа: 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдрийг дуустал.

Тендерийг **2018 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим системээр** тендерийн материалаа ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 10 цаг 30 минут**-аас нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Ус Сувгийн Удирдах газар, Токиогийн гудамж-5 өөрийн байр, С.Чинбаатар Утас: 70157018-223**

ZGM DAILY

**ADB expects Mongolia's GDP growth to be 3.8 percent in 2018**

Inflation estimated to be 8 percent in 2018 and ease to 7 percent in 2019.

**Prime Minister attends Mongolia-China Business Forum**

Mongolia calls for cooperation on establishing railway.

**Fitch affirms MAK's long-term issuer default and bond ratings**

MAK plans to repay USD 157.2 million of the outstanding loans through an expected bond.

**IAAC holds a press meeting on current issues**

Two former PMs Saikhanbileg Chimed and Bayar Sanj have been detained for inquiry.

## ZGM: HIGHLIGHTS

**POLITICS**

President Battulga Khaltmaa receives Mongolian team of hockey players who won Golden Cup and medals from the International Ice Hockey Federation Challenge Cup of Asia 2018, which took place in the Philippines on April 3-8.

Parliamentary Standing Committee on budget discussed a draft loan agreement between the Government of Mongolia and EBRD on 'Ulaanbaatar Solid Waste Modernization Project'.

Independent Authority Against Corruption confirms the arrests of former Prime Ministers Saikhanbileg Chimed and Bayar Sanj.

**ECONOMY**

Mongolia's renewable energy source to increase 95 mWt in 2018 as Sainshand Wind Farm to complete in November, according to the Director of Sainshand Windfarm LLC Oliver Schnorr.

Top 20 Index falls 2.62 percent, to 19,234.93 points. MSE A Index drops 3.08 percent, to 8978.43 points. MSE B Index decreases 0.21 percent, to 10034.5 points. Market cap stands at MNT 2.33 trillion.

**SOCIETY**

With an aim to promote healthy lifestyle and sports to the public, Ulaanbaatar Marathon-2018 international marathon event to be held on May 19.

Munkhzaya Bayartsogt wins a silver medal from the Gunsan Saemangeum International Marathon.

# ADB: Mongolia's economic recovery to continue

***Asian Development Bank releases Mongolia Economic Outlook 2018***

**Tugsbilig.B**
@tugsbiligZGM




Sustained investment into the mining sector will form a basis for continued growth.

Batsaikhan.S / ZGM©

Asian Development Bank (ADB) disclosed the Asian Development Outlook 2018 yesterday and highlighted that Mongolia's economic growth will remain solid in 2018 and 2019, albeit with slight moderation, following a strong performance in 2017 as coal exports and mining investments strengthened.

ADB projects Mongolia's gross domestic product (GDP) growth to moderate to 3.8 percent in 2018 from the 5.1 percent growth in 2017 before rising again to 4.3 percent in 2019. This is following the 1.2 percent growth in 2016. Continued investment in mining, particularly in the development of the Oyu Tolgoi underground mine, will continue to drive growth. Transportation bottlenecks, however, will prevent coal exports from matching 2017 performance, although these will ease somewhat in 2019, according to ADB report.

"Sustained investment into the mining sector will form a basis for continued growth. The strong performance against the International Monetary Fund program is helping to restore investor confidence and improve macroeconomic stability. Continued government commitment to this program will be key in ensuring that macroeconomic buffers are built up, reducing Mongolia's vulnerability boom-bust cycles in the future," remarked Yolanda Fernandez Lommen, ADB Country Director for Mongolia.

Furthermore, ADB expects the inflation to accelerate to 8 percent in 2018 and ease to 7 percent in 2019, from the 4.3 percent recorded in 2017 following the 24.7 percent depreciation of MNT in 2016, which affected import prices on top of higher commodity prices due to drought and higher excise taxes. Rising domestic demand and international oil and food prices, coupled with the effects of looser monetary policy in 2017, will continue to drive inflation higher in 2018. These effects will be less pronounced in 2019 as oil prices and domestic demand subside.

Mongolia's budget deficit is projected to equal 6.4 percent of GDP in 2018 and 5.1 percent in 2019, from 3.9 percent of GDP in 2017, as expenditure on social insurance, welfare, and equipment increases, coupled with a likely reduction in budget revenue as reforms to ease reporting requirements and the tax burden for SMEs take place. A sharp recovery in FDI, financial support from multilateral development partners, and better terms of trade allowed the country to refinance a major part of its external debt. Gross reserves more than doubled, reaching 5.5 months of imports. These developments pushed the value of MNT up by 2.5 percent against the USD. The current account deficit will narrow to 6.3 percent in 2018 before widening to 7 percent in 2019.

Downside risk to the outlook include lower coal and copper prices, disruptions to the successful implementation of the extended fund facility, higher meat prices, interruption to Oyu Tolgoi production or investment, and worsening financial instability arising from the bank restructuring program. Upside risk to growth include higher commodity prices and a possible deal on large infrastructure projects tied to existing mining production. [ZGM]

## ZGM:QUOTE

**Declan Magee**
*Senior Country Economist of Asian Development Bank*

"We are confident that investments in Oyu Tolgoi underground development to continue in 2018 and 2019. Oyu Tolgoi is a big and visible investment for a relatively small economy. On the flipside, if the investment were to be delayed, that is going to have an impact on the economy. Mongolia's GDP is just over USD 11 billion, while Oyu Tolgoi's investment was almost USD 1 billion last year, nearly 10 percent of GDP".

## Fitch affirms MAK's expected IDR, bond rating at 'CCC+'

Fitch Ratings has affirmed Mongolyn Alt (MAK) LLC's expected Long-Term Issuer Default Rating (IDR) at 'CCC+' and the expected rating on the Mongolia-based coal mining company's proposed US dollar notes at 'CCC+' with a Recovery Rating of 'RR4'.

The ratings continue to be based on the capital structure and liquidity of MAK, assuming it completes the proposed bond deal and a debt restructuring. The company plans to repay some of its existing loan facilities that are in default with proceeds from the proposed bond. The terms of the proposed bonds have been revised to include additional collateral. The restructuring terms for the remaining loans, and consents and waivers signed by the respective lenders will also be revised for most lenders to benefit from the same collateral. Fitch has reviewed the revised terms outlined in the signed consents and waivers from each lender and we believe the revised terms will have limited impact on the pro-forma credit profile of the company and we have therefore affirmed the existing ratings.

If MAK is successful in raising USD 200 million in the proposed bond issuance, it now plans to repay USD 157.2 million of the outstanding loans from the European Bank for Reconstruction and Development and Deutsche Investitions-und Entwicklungsgesellschaft mbH. Under the previous terms, it had planned to repay the loans in full with the bond proceeds. Instead, it will now repay in full loans from Golomt Bank and part of the loans from Development Bank of Mongolia. It will also pay 50 percent of the overdue amount (excluding principal) on loans from Eksport Kredit Fonden.

The Long-Term IDR reflects Fitch's expectation that MAK's liquidity and debt maturity profiles will be adequate after the planned bond issue and restructuring of the remaining debt. The rating also incorporates Fitch's expectation that the company will be able to generate positive free cash flows over the medium term, barring a significant deterioration in coal prices. This is based on the assumption that MAK will be able to reduce production costs and capex during moderate coal price weakness. These expectations are counterbalanced by MAK's history of aggressive debt-funded investments, and limited access to external funding, which may heighten the company's liquidity risk if there is a sharp, sustained coal price or demand downturn and unfavourable capital market conditions. [ZGM]

## ZGM: INFOGRAPHIC




**FOREIGN RELATIONS**

## 36 agreements signed as Mongolia-China Business Forum kicks-off

**Oyunbayar.N**
ZGM

Yesterday, Mongolian Prime Minister Khurelsukh Ukhnaa, who is paying an official visit in the People's Republic of China (PRC) at the invitation of his counterpart Li Keqiang, opened Mongolia – China Business Forum with a remarkable speech.

"Mongolia wishes to develop close cooperation on export diversifying sectors, such as agriculture. In addition, we call for cooperation on establishing railway and building satellite towns of Ulaanbaatar," the Mongolian Premier emphasized in his speech. "The Government of Mongolia expresses that it will show complete support to the mutual cooperation of the two sides," he added.

"More than 600 representatives are participating in this forum today. This shows that there is a high cooperation interest between the two countries' entrepreneurs," Chairman of the China Council for the Promotion of International Trade Jiang Zengwei highlighted. He emphasized that it needs to ease Mongolia and China trade issues, reduce obstacles in crossing the border and customs duty. He also noted that investment shall be increased. "In Mongolia, there is a great demand for industrialization. In this regard, China has much experience and therefore, there is an opportunity to develop business cooperation," he added.

During the forum, Mongolian and Chinese companies signed 36 agreements worth USD 4.6 billion. Mongolian Foreign Minister Tsogtbaatar highlights this is the main achievement of this visit. "The key function of the Government is to support entrepreneurs' operations. Widening of the private sector operation will help increase workplaces and expand tax fundament," the minister stressed.

By the end of 2017, volume of Mongolia-China foreign trade reached USD 6.7 billion, a 36 percent increase compared to 2016, and accounts for 63 percent of Mongolia's total foreign trade. The countries have set an objective to increase the volume to USD 10 billion by 2020. During the meeting between PM Khurelsukh and President of the PRC Xi Jinping, sides agreed on several actions within the frame of latter objectivem such as intensifying cooperation mechanisms, reduce non-tariff barriers in trade, activate cooperation in agriculture, tourism and industrial capacity. [ZGM]

# Өдрийн хэмнэл

## ТВ ХӨТӨЛБӨР

**MNB**

- **07.00** “Өглөө” хөтөлбөр /шууд/
- **10.35** “Жив жив” хүүхдийн нэвтрүүлэг /давталт/
- **14.00** “Солиот” Оросын ОАК 7, 8 дугаар анги
- **18.10** “Робокон-2018” Үндэсний роботын тэмцээн
- **20.00** “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр /шууд/
- **23.45** “Гэрэлтэй цонх” үдшийн хөтөлбөр /шууд/

**Bloomberg TV Mongolia**

- **07.30** “Хариуцлага ба үнэ цэнэ” нэвтрүүлэг
- **11.00** “Блумбергийн ярилцах цаг” нэвтрүүлэг
- **14.00** “Технологийн шийдэл” нэвтрүүлэг
- **18.00** “Бизнесийн төв цэг” давталт
- **20.30** “Эврика” нэвтрүүлэг
- **22.30** “Танилц: Япон” нэвтрүүлэг

**БОЛОВСРОЛ HD**

- **08.05** “Бяцхан оцон шувуу Пороро” 24 дүгээр анги
- **10.05** “Төгс бэр” ОАК 15 дугаар анги
- **14.05** “Mongolia's next top model-2017” реалити шоу /7 дугаар хэсэг/
- **17.00** “Сониуч Кеми” хүүхэлдэйн кино 45-50 дугаар анги
- **20.50** “Аяыг таа” шоу нэвтрүүлэг
- **00.10** “Кино миний амьдрал” нэвтрүүлэг

**МОНГОЛ TV**

- **09.30** Тог тог тог /season-5/ 10 дугаар хэсэг
- **12.30** “The Voice of Mongolia” хөшигний ард 12 дугаар хэсэг /халз тулаан-3/
- **14.00** Хүрээлэн амьд ертөнц 17 дугаар хэсэг
- **17.30** “Пэппа торой” /season-2/ 19-21 дүгээр анги
- **20.00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
- **22.30** “Бирмингемийн дээрэмчид” ОАК

## ЗУРХАЙ

**Билгийн тооллын 26**
Хаврын дунд хөхөгчин туулай сарын гурван хөх мэнгэтэй хөх нохой өдөр.
**Үс засуулбал:** Өлзийтэй сайн
**Наран ургах, шингэх:** 06.11-19.36
**Барилдлага:** Үл тохирох
**Шүтэн барилдлага:** Нэр өнгө
**Суудал:** Мод

**Аргын тооллын дөрөвдүгээр сарын 12. Бархасвадь гараг. Билгийн тооллын 27. Чөдөр одтой, хөх нохой өдөр.**
Өдрийн наран 06.11 цагт мандан, 19.36 цагт жаргана. Тухайн өдөр бар, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, лус тахих, хүүхэд үрчлэн авах, гэр, байшингийн суурь тавихад сайн. Нүүдэл суудал хийх, хэрүүл тэмцэл хийх, цөөрөм байгуулахад муу. Өдрийн сайн цаг нь бар, луу, могой, бич, тахиа, гахай болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой.

**“Нора” жүжиг**
**Хаана:** УДЭТ
**Хэзээ:** Өнөөдөр 19.00 цагт
**Тасалбарын үнэ:** ₮ 10-30 мянга

**“Нэргүй од” жүжиг**
**Хаана:** УДЭТ
**Хэзээ:** 04.20-21-ний 18.00-19.00 цагт
**Тасалбарын үнэ:** ₮ 10-20 мянга

**“Лучин Де Ламмермур” дуурь**
**Хаана:** УДБЭТ
**Хэзээ:** 04.21-ний 17.00 цагт
**Тасалбарын үнэ:** ₮ 10-20 мянга

## ОНЦЛОХ ҮЗВЭР



# “Аниргүй орчин”-д бэлтгээрэй

Аймшгийн киноны хорхойтнуудад зориулсан A Quiet Place кино дөрөвдүгээр сарын 6-наас Өргөө кино театрын дэлгэцнээ гарч эхэллээ. Холливудын алдарт жүжигчин, найруулагч Жон Красински найруулж, өөрөө гол дүрд нь тоглосон A Quiet Place кинонд дөрвөн ам бүлтэй гэр бүл чимээ гаргах эрхгүй амьдардаг. Дуу чимээгээр ангуучилдаг сохор мангасуудын ертөнцөд чимээгүй байх нь амьд гарах цорын ганц боломж. Харамсалтай нь, хоёр хүүхэд нь тоглож байгаад санаандгүй чимээ гаргаснаар тэдний аймшигт, амь өрссөн тэмцэл эхэлнэ.
Жон Красинскитэй хамт эхнэр Эмили Блант нь эмэгтэй гол дүрийг бүтээсэн байна. “Аниргүй орчин” бүтээл кино шүүмжлэгчдээс өндөр үнэлгээ авсан бөгөөд Rotten Tomatoes-өөс 100 хувь гэж үнэлсэн нь уг киноны хүлээлтийг нэмэгдүүлээд байна. [ЗГМ]

URGOO CINEMA IMAX

“Өргөө” кино театрт цацагдаж байгаа бусад киноны трэйлерийг энэхүү QR кодыг уншуулж үзнэ үү.

**“5 Tones II” концерт**
**Хаана:** Улаанбаатар чуулга
**Хэзээ:** 04.21-22-ны 19.00 цагт
**Тасалбарын үнэ:** ₮ 15-25 мянга

**“Touch the feeling, Carmen Suite” баллет**
**Хаана:** The Corporate Hotel & Convention Centre
**Хэзээ:** 04.21-нд 19.30 цагт
**Тасалбарын үнэ:** ₮ 30-40 мянга

**“Инээмтгий хүн” тоглолт**
**Хэзээ:** 2018.04.20-ны 19.00 цагт
**Хаана:** The Corporate Hotel & Convention Centre
**Тасалбарын үнэ:** ₮ 70-90 мянга

## ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



**БОСООГООР:**
1.Жууз тэрэгний өөр нэр
2. Анхны хувийн эмнэлгүүдийн нэг
3. Хамгийн түрүүнд ургадаг цэцэг
4. Сэтгэлийн дэм
6. Ардын дуу
8. Будант Альбион гэгддэг орон
10. Дэлхийн хамгийн өндрөөс цутгадаг хүрхрээ (Венесуэл)
12. Саармаг гэсэн утгатай буюу эцэг малыг агталсны дараах нэр
13. Анчдын отоог нэрлэх нэр
14. Еврейн монгол нэр
16. Дэлхийн нарны хорт ягаан туяанаас хамгаалах давхарга

**ХӨНДЛӨНГӨӨР:**
1.ОХУ дахь монгол туургатан
3. Зүдүү, тарчиг
5. Арвайн гурил, шар тос бүхий тахил
7. Гэр, орон байршил тусгаарлагч
9. Ургуудын нэгдэл
11. Буртаг
14. Амтат ургамал
15. Норвеги улсын нийслэл
17. Өршөөл
18. Байлдаан
19. Чингис хаанаас зүрхшээн эзлэгдсэн Найманы хаан

**Өмнөх дугаарын хариу / 04.11**

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ш | А | Х | | Д | | Х | У | Н |
| А | | Э | | А | | У | | А |
| Н | | Э | С | Г | И | Й | | С |
| Х | | | | И | | | | А |
| | Б | А | Р | И | М | А | Л | |
| Б | | | | Р | | | | Р |
| У | | Г | У | А | Н | З | | О |
| Й | | У | | Н | | У | | Я |
| Л | У | У | | З | | Д | А | Л |

## ЗГМ: СУДОКУ

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2 | | | | | 9 | |
| | | | 2 | 4 | | | | 7 |
| | 4 | | | | 7 | 3 | | 6 |
| | | | | 9 | 8 | | 6 | 5 |
| | 3 | 8 | | | 6 | | | |
| | | | | | | 8 | | |
| 1 | 6 | | | | | | | |
| | 7 | | | | | 1 | 8 | |
| | | | 4 | 5 | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 4 | 5 | 2 | 7 | 6 | 3 | 8 | 9 |
| 2 | 9 | 8 | 3 | 1 | 5 | 7 | 4 | 6 |
| 7 | 3 | 6 | 8 | 9 | 4 | 2 | 5 | 1 |
| 8 | 6 | 3 | 4 | 2 | 1 | 9 | 7 | 5 |
| 9 | 2 | 4 | 7 | 5 | 3 | 1 | 6 | 8 |
| 5 | 7 | 1 | 9 | 6 | 8 | 4 | 3 | 2 |
| 3 | 5 | 9 | 1 | 8 | 7 | 6 | 2 | 4 |
| 6 | 1 | 7 | 5 | 4 | 2 | 8 | 9 | 3 |
| 4 | 8 | 2 | 6 | 3 | 9 | 5 | 1 | 7 |

(Өмнөх дугаарын хариу)

## ЦАГ АГААР

**УЛААНБААТАР**

| IV.12 | IV.13 | IV.14 | IV.15 | IV.16 |
|---|---|---|---|---|
| 9° / 2° | 4° / -3° | 12° / -5° | 16° / -1° | 18° / 3° |
| 12 м/с / 8 м/с | 13 м/с / 10 м/с | 7 м/с / 5 м/с | 9 м/с / 5 м/с | 8 м/с / 5 м/с |
| Бага зэргийн хур тунадас | Бага зэргийн хур тунадас | Багавтар үүлтэй | Багавтар үүлтэй | Багавтар үүлтэй |




## ЗГМ: КОМИК

## ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

| | | |
|---|---|---|
| БЭЭЖИН-МОКВА | 07.45 | 14.28 |
| МОСКВА-УБ | 21.35 | 07.30 |
| УБ-БЭЭЖИН | 07.15 | 14.04 |
| УБ-ЭРЭЭН | 20.00 | 10.25 |
| УБ-ЭРХҮҮ | 21.10 | 02.40 |
| ЭРХҮҮ-УБ | 15.35 | 06.20 |
| УБ-СҮХБААТАР | 21.15 | 05.12 |
| СҮХБААТАР-УБ | 20.55 | 05.03 |
| УБ-ЭРДЭНЭТ | 20.30 | 07.45 |
| УБ-ЗАМЫН-ҮҮД | 17.20 | 07.05 |
| ЗАМЫН-ҮҮД-УБ | 21.35 | 09.55 |
| УБ-САЙНШАНД | 19.15 | 19.15 |

## НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

| | | |
|---|---|---|
| УБ-ХОНКОНГ | 06.25 | 10.55 |
| УБ-БУСАН | 07.30 | 12.05 |
| УБ-ХАНБУМБАТ | 08.40 | 09.50 |
| УБ-МОСКВА | 09.15 | 10.55 |
| ХАНБУМБАТ-УБ | 10.40 | 11.45 |
| МОСКВА-БЕРЛИН | 11.55 | 3.35 |
| ХОНКОНГ-УБ | 12.05 | 16.45 |
| БУСАН-УБ | 13.05 | 16.10 |
| БЕРЛИН-МОСКВА | 14.55 | 18.30 |
| УБ-БЭЭЖИН | 17.55 | 20.10 |
| БЭЭЖИН-УБ | 21.10 | 23.40 |

Syndicated articles from

FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

**BP компани Умард тэнгист хоёр төсөл хэрэгжүүлнэ**

Аллигин Ворличийн төсөл нь BP-гээс сүүлийн жилүүдэд Их Британид оруулж буй томоохон хөрөнгө оруулалт. > 10

**Жон Крайанд Deutsche Bank долоон сая евро төлнө**

Ажил олгогч нар халагдаж буй дээд удирдлагатай ихэвчлэн нөхөн төлбөр олгох хэлэлцээр байгуулж салдаг. > 10

**АНУ-ын хотуудад цахилгаан дугуйн шеринг нэвтэрлээ**

Цахилгаан хөдөлгүүр бүхий ойрын зайн тээврийн хэрэгсэл АНУ-д хэрэглээнд шуурхай нэвтэрч эхэллээ. > 10

BBM©

Хөрөнгө оруулагчид хувьцаа худалдан авах буюу өрийн бичигт хөрөнгө оруулахаас эмээж эхлэв.

# АНУ-ын хориг Оросын компанийг дампуурууллж магадгүй

◄1

Оросын Засгийн газар Дерипаскагийн эрчим хүч, хөнгөн цагааны эзэнт гүрэнд дэмжлэг үзүүлэхгүй бол цаашид хэвийн ажиллахад хүндрэл учирсныг шинжээчид анхааруулав. Москва дахь Renaissance Capital фирмийн ерөнхий эдийн засагч Олег Кузьмин "Хэрэв төрийн дэмжлэг шаардлагатай нь тодорхой болбол туслах нь гарцаагүй. 1990-ээд оноос хойш Оросын Засгийн газар гол компаниудын ажиллагааг үргэлжлүүлж, өрийг нь төлүүлэхийн тулд дэмжсээр ирсэн" хэмээв.

Хориг Оросын томоохон олигархуудын халаасыг нимгэлээд зогсохгүй өрнөдийн байгууллагууд улс төрийн эрсдэлээс болгоомжлон хувьцааг нь худалдан авах буюу өрийн бичигт хөрөнгө оруулахаас эмээхэд хүргэлээ. Хөрөнгө оруулагчид түүнчлэн хоригт нэр нь ороогүй Оросын тэрбумтнуудын хянадаг компаниудын хувьцааг ч зарж эхэлсэн байна. 2015 онд дампуурахад ойрхон байсан олигарх Игорь Зюзиний эзэмшдэг Mechel уул уурхайн компанийн хувьцаа даваа гарагийн байдлаар 16 хувь унажээ. Хөрөнгө оруулагчид одоо хохирлын бүрэн хэмжээг тооцохын тулд хоригт хамрагдсан олигархуудад цаашид учирч болзошгүй хүндрэлийг тооцох хэрэгтэй боллоо.

**Лондоны бирж дээр Оросын хувьцаа уналаа**
(Оросын IOB индекс)

Хөрөнгө оруулагчид хоригт хамрагдсан эсэхийг үл харгалзан Лондонд бүртгэлтэй Оросын компаниудын хувьцааг даваа гарагт худалдаж эхэлснээр Norilsk Nickel-ийн хувьцааны үнэ 19, Severstal-ынх 13.2, Polimetal-ынх 13 хувиар тус тус унасан байна. Гэвч хамгийн том уналт EN+-ийг хүлээж байсан агаад хувьцааных нь үнэ 30 хувиа алдаад байна. Харин Хонконгийн бирж дээр Rusal компанийн үнэлгээ 50 хувиар унасан нь Оросын компаниудын дунд хамгийн том алдагдал болов.

Оросын олигархууд Лондоныг дэлхийн санхүүгийн зах зээлд гарах үүд хаалга, Британид байр сууриа бэхжүүлж, компанийн засаглалын итгэлийг дээшлүүлэх боломж гэж үзсээр ирсэн юм. EN+-ийн хараат бус хоёр захирал Хятадын хөрөнгө оруулагч Жао Гуанминь, Францын банкны төлөөлөгч Доминик Фрэйссе нар компанийн захирлуудын зөвлөлөөс гараад байна. Одоо зөвлөлийг тэргүүлж буй Британийн сайд асан Грег Баркер үлдэх эсэх нь олны анхаарлыг татлаа. Түүнээс энэ тухай тодруулахад хариу өгсөнгүй.

Дэлхийд хамгийн томд тооцогдох Лондоны Металлын бирж баасан гарагт Rusal-ын хөнгөн цагааны арилжааг үргэлжлүүлэхээ мэдэгдсэн. Glencore-ын захирал Иван Гласенберг Rusal-ын захирлуудын зөвлөлөөс гарч буйгаа зарлажээ. Хоригт өртсөн Оросын бусад компани амралтын өдрүүдэд яаралтай арга хэмжээ авч, өрнөдийн түншүүдэд нь тусах АНУ-ын хоригийн нөлөөг бууруулж чадсан байна. Renova компани хяналтын багцыг нь эзэмшдэг тэрбумтан Виктор Вексельбергийн Швейцарын Sulzer инженерингийн компани хоригийн нөлөөг сааруулахын тулд Renova-гийн багцыг 48.83 хувь хүртэл бууруулж, таван сая ам.долларын хувьцаа буцаан худалдан авахаар шийдвэрлэснээ зарлав.

Оросын урт хугацааны ирээдүйд найдаж буй хөрөнгө оруулагчид хүртэл өнөөгийн тодорхойгүй байдлын улмаас унасан хувьцааг худалдан авах эсэхээ сайтар тунгаах шаардлага тулгарчээ. Hermes Investment фирмийн шинжээч Гари Гринберг "2014 онд Украйн руу орсон үеэс ялгаатай. Тэр үед байдал нэлээд тодорхойгүй байсан учир гол тоглогчид юу хийхийг ажиглах хэрэгтэй байсан. Гэхдээ одоо дохио дуугарангуут худалдаж аваад эхэл гэсэн үг биш" хэмээн анхааруулав.

FT

# Ikea бизнес загвараа өөрчилж байна

**Ричард Милне**

Ikea компанийн шинэ захирал худалдан авалтын шинэ хэв маяг нэвтэрч буйг харгалзан уламжлалт жижиглэн худалдааг халж, онлайн борлуулалт руу чиглэсэн бизнесийн өөрчлөлт хийхээ амлалаа. Есдүгээр сард дэлхийд тэргүүлэгч тавилга үйлдвэрлэгчийн захирал болсон Жозеф Бродин Financial Times-т өгсөн ярилцлагадаа өөрийнх нь санаачилсан гурван жилийн стратегийн дагуу тус компани бүх улсад боломжийн үнээр хүргэлтийн онлайн үйлчилгээ нэвтрүүлж, дэлгүүрүүдээ хотын захаас төв рүү шилжүүлнэ хэмээн онцлов. Түүнчлэн Ikea тавилгыг шууд худалдахын оронд зээлээр өгөх, виртуал бодит байдлыг ашиглан айл гэрийн дотоод засалд зөвлөх, дэлгүүрийн шинэ формат ашиглах зэрэг арга хэмжээ авахаар төлөвлөжээ.

Тэрбээр "Бид уламжлалт бизнесээ халах цаг үед ирлээ. Өөрчлөлт асар түргэн байх болно" хэмээсэн юм. Billy номын тавиур, Ektorp зөөлөн сандал гэх мэт нэрийн бараагаараа алдартай Ikea хэрэглэгчид дэлгүүрт нь ирж, тавилгаа аваад гэртээ аваачиж угсрах замаар явагддаг өртгийг бууруулах бизнес загварт удтал тулгуурлаж ирсэн байна. Гэвч одоо хотын оршин суугчид хувийн машинаас татгалзаж эхэлсэн, Amazon мэтийн онлайн борлуулагчдын өрсөлдөөн ширүүссэн, хэрэглэгчид хүргэлт, угсралтад илүү мөнгө төлөх бэлтгэлтэй болсон зэрэг шинэ нөхцөл байдалд зохицох шаардлага тулгарчээ.

Ноён Бродин дээрх байдалд хариу өгөхийн тулд Ikea-гийн уламжлалт таван жилийн төлөвлөгөөг 2019-2021 оны стратеги болгон баталлаа. Тэрбээр "Энэ бол сэтгэлгээний асуудал. Бид аажмаар арван жилээр төлөвлөж, өөрчлөхийг хүсэхгүй байна" гэв. Хамгийн том шинэчлэлийн нэг нь дэлхий даяар хотод суурьших хүмүүсийн тоо нэмэгдэж буй тул Ikea хотын төвд дурлаж эхэлсэн явдал. Ноён Бродин хотын хэрэглэгчдийг анхаарахын дээр "Бид хотын төв рүү тэмүүлэх болно" гэсэн юм. Тус компани дэлхийн 10 том мега хотыг онилсны дотор Лондон, Нью Йорк, Токиод олон жижиг дэлгүүр туршилтаар ажиллуулахаар төлөвлөжээ.

Ikea Стокгольмд зөвхөн гал тогооны тавилгаар дагнасан дэлгүүр нээсэн бол Мадридад хувцасны шүүгээ, зөөлөн гудас борлуулах цэгүүдийг туршиж буй. Захирал цааш нь ярихдаа "Өөрчлөх, турших, өөрсдийгөө сорин шинэ замаар урагшлах онцгой гурван жил байх болно" хэмээв. Ноён Бродин компаниа "өсөлтөөр өлсөж байна" гэж тодорхойлов. Эднийх 34 тэрбум еврогийн борлуулалтынхаа тав орчим хувийг онлайнаар хийж байгаа бол энэ үзүүлэлт Британид 10 хүрээд байгаа юм. Ikea Британид тавилгыг түрээсээр хэрэглүүлэх боломжийн талаар судалгаа явуулж байна. Шинэхэн захирал үүнийг судлах нь бидний хүсэл гэсэн боловч нарийн зүйлийг тодруулсангүй.

FT

# Норвегийн шийдвэр бусад санд боломж олголоо

**Хавиер Эспиноза**

Норвеги улс баялгийн сандаа хувийн хувьцаа худалдан авахыг хориглолоо. Гэхдээ нэг их наяд ам.долларын хөрөнгөөсөө сэргээгдэх эрчим хүчний дэд бүтцэд зарцуулах үүд хаалгыг нээв. Газрын тосны орлогоос бүрдсэн уг сангийн жилийн тайланд дурдсанаар Норвегийн Сангийн яам дэлхийн хамгийн том баялгийн сангийн загвар хувийн хувьцаа худалдан аваад тохирохгүй гэж үзсэн байна. Гэвч дэд бүтэц рүү хандах хоёр ч удаагийн боломжоос татгалзсаныхаа дараа салхин ферм, нарны парк зэрэгт хөрөнгө оруулж, экологийн эрх хэмжээгээ хэрэгжүүлэхэд сангаа ашиглах эсэхийг хянаж үзэхээ мэдэгдэв.

Норвегийн Сангийн сайд Сив Женсен Financial Times сонинд ярихдаа "Сангийн хувьд бидний сонгосон загварт хувийн хувьцаа тохирохгүй. Хамгийн том бэрхшээл нь ил тод байдлын асуудал. Бид олон нийтэд мэдээллээ ил байлгах ёстой" гэжээ. Сангийн яаманд газрын тосны хуримтлалыг бусад томоохон хөрөнгө оруулагчдын адил төрөлжүүлэхийг дэмжигчид болон тус сан бүртгэлтэй компаниудад дунджаар 1.4 хувь эзэмшиж, өндөр үнэлгээтэй сан болсон нь Норвегийг амжилтад хүргэсэн гэж үздэг хэсгийн хооронд маргаан өрнөсөн юм.

Норвегийн хувийн хувьцааг ажигладаг шинжээчдийн бүлгийг тэргүүлдэг Шведийн судлаач Пер Стромберг саяын шийдвэр гайхалтай зүйл биш гэжээ. Тэрбээр "Тэд дотооддоо үлэмж эсэргүүцэлтэй тулгарсан. Зарим нь идэвхтэй хөрөнгө оруулалтын ач холбогдлыг үл зөвшөөрдөг. Би бодлогын өөрчлөлтөд ерөнхийд нь талархаж байна. Гэхдээ энэ нь ирээдүйд өгөөж буурснаар илрэх байх" хэмээн тайлбарлав. Хувийн хувьцааны салбар цэцэглэж, худалдан авдаг группүүд асар их мөнгө гарган сангаа арвижуулж буй үед Норвеги ийм шийдвэр гаргалаа. Уг шийдвэр өрсөлдөөнийг багасгах учир дээрх мэдээг сонссон зарим хөрөнгө оруулагч амсхийж эхэллээ. Хувийн хувьцаанд хөрөнгө оруулагч нэг эх сурвалж "Норвегиэс сайхан мэдээ ирлээ... үлдсэн бидэнд сайн хэрэг" гэжээ. Хатагтай Женсен хэлэхдээ "Тус улс сангийн менежментэд өөрчлөлт хийхдээ маш болгоомжтой хандаж ирсэн. Энэ нь ч цаг хугацаа өнгөрөх тусам сайн нөлөө үзүүлдэг" хэмээв. Тус сан хөрөнгийн биржид бүртгүүлэхийг эрмэлзэж буй бүртгэлгүй компаниудад хөрөнгө оруулахыг зөвшөөрч байгаа. Засгийн газар энэ онд сангийн үйл ажиллагаанд хамаатай хэд хэдэн асуудал хэлэлцсэн. Үүний дотор санг тусдаа байгууллага болгох эсэх, газрын тосны санг удирддаг төв банкны зөвлөмжийн дагуу нефть, хийн хувьцаанаас салах уу гэх мэт асуудлыг хэлэлцсэн байна.

**Дэлхийн томоохон баялгийн сангууд**
(Нийт хөрөнгө, тэрбум ам.доллар)




Norges Bank©

Саудын Арабын улсын хөрөнгө оруулалтын сан өнгөрсөн жил 40 тэрбум ам.долларын үнэлгээтэй Blackstone санд 20 тэрбумыг оруулахаа зарласан. Private Equity Laid Bare номыг зохиогч Оксфордын их сургуулийн санхүүгийн профессор Людовик Фалиппоу "Норвегийн хувьд хувийн хувьцааны загвараар ажиллахад түвэгтэй. Үнэ, зардлаа дураараа тогтоодог сангуудаар дамжуулан хөрөнгө оруулаад санаа амар суухад бэрх. Тэд ил тод байдлаа дээшлүүлж магадгүй боловч ямар ч мэдээлэл өглөө гэсэн түүнийг нь боловсруулахад хүнд бөгөөд олонх санд урамшуллын систем нь зохицуулалтгүй байдаг" хэмээн өгүүлэв.

FT

Syndicated articles from
FINANCIAL TIMES

© The Financial Times Limited [2015]. All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

# BP компани Умард тэнгист хоёр төсөл хэрэгжүүлнэ

BBM©

**Эндрю Уорд**

Шетландын арлуудаас өрнө зүгт орших Аллигины, Умард тэнгисийн төвд орших Ворличийн ордыг 2020 оноос тус тус ашиглалтад оруулж, өдөрт нийт 30 мянган баррел тос олборлохоор тооцоолж байна.

Хэмжээний хувьд жижигт тооцогдох уг хоёр орд эдүгээ ашиглаж буй газрын тос, шатдаг хийн том ордуудад ойр байрладаг тул шинээр дэд бүтэц үүсгэснээс хавьгүй хямд өртөг зардлаар олборлох боломжтой.

Жижиг ордуудыг нэмж ашиглах нь Royal Dutch Shell-ийн Брент зэрэг хуучны том ордын нөөц шавхагдах үед Умард тэнгисийн олборлолтын хугацааг сунгаж өгөх сайн талтай.

BP болон Shell компани сүүлийн хэдэн жилд Умард тэнгис дэх хуучин ордуудынхаа ихэнхийг зарж, шинэ орд илрүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулсан.

Shell компани Шетландын арлуудаас зүүн умардад орших Пингвиний ордыг нэгдүгээр сараас олборлож эхэлжээ. Энэ нь Их Британийн хувьд сүүлийн зургаан жилд шинэ орд ашиглаж буй хэрэг юм. BP компани өнгөрсөн онд ашиглалтад оруулсан 4.4 тэрбум фунт стерлингийн өртөгтэй Quad 204 төслийн ордын ойролцоо, Шетландын арлуудаас өрнө зүгт оршдог Клейр Рижийн ордыг удахгүй олборлож эхэлнэ. Клейр Рижийн төсөлд тус компани олон тэрбум ам.долларын хөрөнгө зарцуулсан.

Аллигины, Ворличийн төсөл нь BP-гээс сүүлийн үед эх орондоо буюу Их Британид оруулж буй хамгийн том хөрөнгө оруулалт болж буйг тус компанийн Умард тэнгисийн олборлолт хариуцсан тэргүүн Ариэль Флорес тайлбарлав.

"Quad 204, Клейр Риж шиг том биш ч, дээрх хоёр орд нь Умард тэнгист BP-гийн олборлож буй ордуудын тун ашигтай нь" хэмээн хатагтай Флорес мэдэгдсэн юм.

Шинэ ордуудыг харьцангуй богино хугацаанд ашиглалтад оруулах гэж байгаа нь BP зардлаа хэмнэж, шат дамжлагыг цөөрүүлсний үр дүн хэмээн тэрбээр өгүүлэв. Дэлхийд хамгийн эртнээс олборлож эхэлсэн, хамгийн өндөр зардалтай ордууд байрладаг Умард тэнгисийн хотгорын үйлдвэрлэлийн зардлыг 2014 оны газрын тосны үнэ уналтаас хойш үлэмж танажээ.

Аллигины орд нь BP, Shell-ийн тус бүр 50 хувийн хөрөнгө оруулалттай түншлэлийн үр дүн. Уг хоёр ордыг нэмж ашигласнаар хоёр компани Их Шихаллионы бүсээс 20 сая баррель газрын тос нэмж олборлохоор төлөвлөжээ. Ордоос олборлох газрын тосыг BP-гийн Glen Iyon хэмээх олборлох хөлөгт нийлүүлэх юм.

Ворличийн ордын гуравны хоёр нь BP-гийн мэдлийнх. Харин 30 баррел газрын тостой тэнцэх 34 хувийг нь Ithaca Energy компани эзэмшдэг. Ithaca Energy өөрийн хувиа Их Стеллагийн бүсэд орших өөрийн хөлөг онгоц руу damжуулна.

Умард тэнгист газрын тос олборлоход өрсөлдөгч компаниудын хамтын ажиллагаа чухал үүрэгтэй. Учир нь Умард тэнгисийн хотгорт үлдээд буй нөөцийг ашиглаж чадах эсэх нь одоо ашиглаж буй, зэргэлдээх том ордуудын damжуулах хоолой, хөвөгч тавцан, хөлөг онгоцуудаас хамаардаг.

FT

# Жон Крайанд Deutsche Bank долоон сая евро төлнө

**Лаура Нунан**

Албан тушаалаа таван жил хаших ёстой гүйцэтгэх захирал Жон Крайаныг гурван жил болоогүй байхад нь огцруулсныхаа төлөөсөнд Deutsche Bank долоон сая евро төлж болзошгүй болов.

Германы зээлийн гол банкны ерөнхий захирал Паул Ахляйтнер өнгөрсөн долоо хоногт шинэ гүйцэтгэх удирдлага шаардлагатай болсныг сүр дуулиантай зарлаж британи Жон Крайаныг сүр дуулиантай огцруулсан. Deutsche Bank-ны жижиглэнгийн салбарыг тэргүүлж байсан Кристиан Сьюинг аврагчийн дүрд тодорч, шинэ гүйцэтгэх захирлаар томилогдов.

Арваадхан хоногийн өмнө ноён Крайан өөрийн удирдлагын багийг Deutsche Bank-ны ерөнхий захирал Ахляйтнер тэргүүтэй хяналтын зөвлөлтэй "үзэл бодлын зөрчилгүй" тул албаа цаашид ч хашна хэмээн 98 мянган ажилтандаа баталж байжээ.

Ноён Крайан нь Deutsche Bank зардлаа танаж, IT тогтолцоогоо сайжруулж, орлого багатай ажиллагаагаа цөөлөхөд чиглэсэн Strategy 2020 төлөвлөгөө хэрэгжиж дуусах 2020 оны долдугаар сар хүртэл ерөнхий захирлаар ажиллах ёстой байсан юм. Deutsche Bank-ны бэрхшээлийг дутуу үнэлсэн хэрэгт буруутаад байгаа ноён Крайаныг гүйцэтгэх захирлаар улируулан томилох тухай ч ярьж байсан удаатай.

Deutsche Bank-ны жил тутмын тайланг үзвэл ноён Крайан болон Deutsche Bank-ны удирдлагын багийн бусад гишүүн ч "банкны санаачилгаар хугацаанаасаа өмнө үүрэгт ажлаасаа чөлөөлөгдвөл халагдсаны нөхөн төлбөр авах эрхтэй". "Журмын дагуу хоёр жилээр тооцдог халагдсаны нөхөн төлбөрийн дээд хэмжээ нь гэрээнд заагдсан үлдэгдэл хугацаанаас хэтрэхээргүй байх ёстой" хэмээн тус банкны жил тутмын тайланд тайлбарлажээ.

Уг төлбөрийг гүйцэтгэх захирлын сүүлийн жилүүдийн цалин, цаашид ажиллах жилүүдэд олгохоор төлөвлөсөн цалингийн хэмжээнд үндэслэн тогтоодог. Ноён Крайаны 2017 оны нийт цалин 3.4 сая евро байсан тул тэтгэврийн мөнгө, бусад урамшууллыг нэмж тооцвол долоон сая орчим евро болно.

Франкфуртэд байрладаг тус банкны төлөөлөгч нарийн учрыг тайлбарлаагүй ч "Жон дараагийн таван жилээр гэрээлж тооцсон нөхөн төлбөр авна" хэмээн мэдэгдлээ.

Deutsche Bank-наас гурван жил тутамд олгодог шагналт цалингаас "ойлгохгүй байна" хэмээн татгалзаж байсан тус банкны нэгэн удирдлага олговол зохих мөнгийг тооцож таарна хэмээн ноён Крайаны анд нэгэн өгүүлж байв. Харин ноён Крайан тайлбар өгөхөөс татгалзлаа.

Сүүлийн хэдэн жилд хорголоо тоолсон цалин, өчүүхэн урамшуулалд урам хугарсан Deutsche Bank-ны бусад удирдлага нөхөн төлбөрийг эсэргүүцэж болзошгүй ч хөрөнгө оруулагчид төдийлэн дургүйцэхгүй. Тус банктай холбоотой "сэтгэлээ зовоох шаардлагагүй зүйл нь Жон Крайанд олгох нөхөн төлбөр" хэмээн нэгэн шинжээч өгүүлэв. АНУ дахь хөрөнгө оруулалтын салбарынх нь сул ажиллагаа, ноён Крайаны удирдлагын баг амлаад байсанчлан хурдан шийдэгдэгүй, зардлаа танах гэх мэт стратегийн шинжтэй бэрхшээл Deutsche Bank-нд тулгарч буйг тэрбээр анхааруулсан юм.

Шүүхдэлцэх нь "аль алиндаа ашиггүй" тул ажил олгогч нар халагдаж буй дээд удирдлагатай нөхөн төлбөр олгох хэлэлцээр байгуулж салдгийг Fox & Partners-ын эксперт Ронни Фокс тайлбарлаж байна.

Deutsche Bank-ны жил тутмын тайланг үзвэл тус банкны хөрөнгө оруулалтын банкны тэргүүн байсан Жефф Урвин жилийн өмнө нөхөн төлбөр авалгүй халагдсан. "Хоёр тал хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр" халагдсаны нөхөн төлбөр олгоогүйг уг тайланд дурджээ. Түүний халааг авсан Маркус Шёнк ч нөхөн төлбөргүй халагдах гэж байгаа нь өнгөрсөн долоо хоногт тодорхой боллоо. Ноён Шёнк "өөрийн шийдвэр"-ээр халагдаж буйг Deutsche Bank тайлбарласан юм.

FT

**Тим Брэдшоу**

BBM©

# АНУ-ын хотуудад цахилгаан дугуйн шеринг нэвтэрлээ

Цахиурын хөндийд таарсан хүмүүсээс тээврийн хэрэгслийн ирээдүйн тухай асуугаад үз. Бүгдийнх нь нүд гэрэлтэж бөөн боломж тодорно. Зарим нь хэдхэн жилийн дараа жолоочгүй машин замаар дүүрнэ гэх бол зарим нь нисдэг машин бүтээх оролдлогыг дурдацгаана. Харин асуултыг Uber, Lyft-ын гүйцэтгэх захирал асан Трэвис ВандерЗанденаас асуувал "цахилгаан унадаг дугуй" гэсэн энгийн хариу хэлэх болов уу.

Хөрөнгө оруулагчид цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуйг их сонирхож байна. Хүссэн газраасаа аваад, хүссэн газартаа орхиж болдог цахилгаан унадаг дугуй, скутер түрээслэдэг ноён ВандерЗандены Bird Rides старт-ап болон ижил төстэй бусад компанид сүүлийн хэдхэн сарын дотор хэдэн зуун сая ам.долларын хөрөнгө цутгалаа. "Дараагийн 10-20 жилд тээврийн хэрэгсэл санаанд багтамгүй өөрчлөгдөнө" хэмээн ноён ВандерЗанден өгүүлэв. Тэрбээр автомат жолоодлоготой автомашин, Илон Маскийн хонгилоор өндөр хурдтай зорчдог тээврийн хэрэгслийг жишээлж байлаа. "Гэхдээ өнөөдөр ямар эрэг үр дүн гарч байгаа билээ. Гэр хүрэх ойрын зай туулахад зориулсан цахилгаан унаа хэрэглэж байгаа хүн алга".

Ийм ижил бодолтой Uber компани даваа гарагт 100 сая ам.доллараар Jump компанийг худалдаж авлаа. Jump нь хаана ч орхиж болдог цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуйн түрээсийн үйлчилгээ эрхэлдэг. Bird Rides-ийн скутер, Jump-ын унадаг дугуйнд GPS суурилуулсан тул үйлчлүүлэгчид ухаалаг утсаараа хамгийн ойр байгааг нь олж, аппликэйшн ашиглан түрээслэх боломжтой. Зорьсон газартаа хүрмэгц унаагаа тусгай зогсоол, эс бөгөөс гудамжны буланд орхиж болно.

Цахилгаан хөдөлгүүртэй ойрын зайн тээврийн хэрэгсэл хэрэглээнд шуурхай нэвтэрч эхэллээ. Uber хоёр сар гаруй хугацаанд Сан Франциско 250 ширхэг Jump дугуйг өөрийн аппликэйшнд нэгтгэв. Ноён ВандерЗанден Санта Моникагийн гудамжны буланд анхны 10 Bird дугуй түрээсэлж эхэлснээс хойш жил ч болоогүй байна. Цахилгаан хөдөлгүүрт скутерын тухай анх сонсоод "Гүйлгээ ихтэй эд байж чадахгүй" хэмээн бодсоноо Санта Моникагийн Upfront Ventures компанийн хөрөнгө оруулагч Марк Састер хүлээв. Гэвч оффисынх нь цонхны доогуур өнгөрөх Bird скутерыг байнга харсаар байгаад уг үйлчилгээг Лос-Анжелесийн нарлаг гудамжинд "хагас жилийн дараа нийтийн хэрэглээ болох нь" гэсэн бодолтой болжээ. Гуравдугаар сард 100 сая ам.долларын хөрөнгө оруулалт татсан Bird Rides эдүгээ Лос-Анжелес, Сан Диего, Сан Францискогийн булан, Остин, Вашингтоны Колумбын тойрогт 1000 гаруй скутер түрээсэлж байна. "Хэрэглээнд тун хурдан нэвтэрсэнд нь гайхсан" Bird-ийн анхны хөрөнгө оруулагч Goldcrest Capital-ын түнш Дэниэль Фридлэнд ярьсан юм.

Оны эхээр Цахиурын хөндий ч уг санааг шүүрч авлаа. Сан Франциско Хятадын Mobike, Ofo хоёртой ижил шахам LimeBike, Spin хэмээх унадаг дугуйн шерингийн хоёр старт-ап компани үүслээ. АНУ-ын олон арван хотод энгийн унадаг дугуйн шеринг үйлчилгээ нэвтрүүлснийхээ дараа, оны эхээр хоёр компани цахилгаан хөдөлгүүрт скутерээр паркаа өргөжүүлэв. "Энэ онд бид цахилгаан хөдөлгүүрт загвараа олшруулах зорилготой" хэмээн LimeBike-ийг үндэслэгчдийн нэг, гүйцэтгэх захирал Тоби Сан өгүүлэв.

Анх 2017 оны нэгдүгээр сард байгуулагдсан LimeBike хэдийнэ 130 сая ам.долларын хөрөнгө оруулалт татаад байна. Тус компани өөрийн цайвар ногоон цахилгаан унадаг дугуйгаа энэ онд хэдэн зуун мянгаар нэмэгдүүлэхээр төлөвлөжээ. Spin ч мөн адил. "Бидний ажилладаг бүх зах зээл скутерт аажим шилжиж байгаа" хэмээн Spin-ийн ерөнхийлөгч, үндэслэн байгуулагчийн нэг Ювин Пун тайлбарлав. Автомашиныг цахилгаан унаагаар солих санаа нь инновац хэрэгжүүлэгч, хүрээлэн буй орчныг хамгаалагч, хотын нийтийн тээврийн зарим удирдлагад таалагддаг ч Сан Франциско болон бусад хотод хөглөрөх олон дугуй, скутер хэдийнэ иргэдийн гомдоллох шалтгаан болж байна.

Хэрэглэгчдийн эрэлт, хэрэглээ нь зохицуулах байгууллагын маргааныг төдийгүй ямар тээврийн хэрэгсэл ноёлох ёстойг тодорхойлогч хүчин зүйл болж эхэллээ. "АНУ-д хүмүүс дөрөөтэй цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуйг машинаас илүүд үзэцгээнэ. Учир нь автомашиныг персонал компьютер гэвэл цахилгаан унадаг дугуй iPhone гэсэн үг" хэмээн ухаалаг утас, дижитал технологид хөрөнгө оруулагч Керт МакМастер ярилаа. Түүний хөрөнгө оруулсан Nere компани өрнөд Европод дуртай газартаа орхиж болдог цахилгаан хөдөлгүүрт унадаг дугуйн үйлчилгээг нэвтрүүлээд бараг хоёр жил болж байгаагаа мэдэгдсэн юм.

FT

## Эдийн засаг

# Эдийн засаг эрсдэл дунд өндийнө

***ДНБ-ий өсөлт энэ онд саарч, ирэх онд нэмэгдэх таамаг гарлаа***

**Б.Баярмаа**
@bayarmaaZGM

Өнгөрсөн онд өрхийн хэрэглээ сэргэж, хөрөнгийн нийт хуримтлал нэмэгдсэн нь эдийн засгийг өөдрөгөөр үнэлэхэд нөлөөлжээ.

С.Батсайхан / ЗГМ©

Ирэх жилүүдэд эдийн засгийн "цаг агаар" ямар байх талаар олон улсын мэргэжлийн байгууллагууд ялгаатай таамаг дэвшүүлж байна. Дотоодын эдийн засагчид эдийн засгийн өсөлт өнгөрсөн оны 5.1 хувийн үзүүлэлттэй дүйцэхүйц үр дүн хүлээж байгаа. Харин олон улсын байгууллагууд 3.1-6.6 хувийн өсөлттэй байх хэд хэдэн таамаг дэвшүүлээд буй.

Монгол Улсын ДНБ-ий өсөлт энэ онд 6.6 хувьд хүрэх хамгийн өөдрөг таамгийг судалгааны BMI байгууллагаас гаргасан. Харин Францын NATIXIS байгууллага уг үзүүлэлт оны эцэст 4.2 хувь болно гэсэн бол Дэлхийн банкнаас 3.1 хувь гэсэн таамаг дэвшүүлсэн. Тэгвэл Азийн хөгжлийн банкнаас ДНБ-ий өсөлт 2018 онд 3.8, 2019 онд 4.3 хувь байх таамгийг танилцуулсан нь бусад байгууллагуудын өгсөн "дүн"-тэй харьцуулахад дундаж үнэлгээ юм.

Тус байгууллага өмнө нь энэ оны эдийн засгийн төлөвийг 3.8 хувиас бага үзүүлэлтэй гарна гэж үзэж байв. Яг жилийн өмнө 2018 оны ДНБ-ий өсөлтийг таамаглахдаа 2.5 хувьд хүрнэ гэж мэдэгдэж байсан. Харин өнгөрсөн есдүгээр сард гурван хувьд хүрэх таамаг танилцуулж байв. Эдгээртэй харьцуулбал хамгийн сүүлийн таамаг болох 3.8 хувийн өсөлт нь илүү өөдрөг үзүүлэлт болж байна.

Монгол Улсын эдийн засгийг эерэгээр төсөөлж, таамаглахад голчлон юу нөлөөлж буйг задалж харъя. Өнгөрсөн онд БНХАУ-д экспортолсон коксжих нүүрсний хэмжээ 33.4 сая тоннд хүрч түүхэн амжилт тогтоосон. Мөн "Оюутолгой"-н далд уурхайн бүтээн байгуулалт урагшилсан нь ихээхэн нөлөөлжээ. 2017 онд уул уурхайн салбарын өсөлт 6.9 хувийн бууралттай гарсан. Гэхдээ уул уурхайн үйлдвэрлэлийн хэмжээ өссөн тул энэ нь аж үйлдвэрийн салбарын өсөлтөд 0.2 нэгж хувиар нөлөөлжээ.

### Оюутолгойн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт саатах эрсдэл бий

Түүнчлэн уг салбартай холбоотой хөрөнгө оруулалтаас үүдэн үйлчилгээний салбар сэргэсэн нь өсөлтөд 4.3 нэгж хувь нэмсэн байна. Харин хөдөө аж ахуйн салбар 0.6 нэгжээр нэмэр оруулжээ. Үүнээс гадна өнгөрсөн онд өрхийн хэрэглээ сэргэсэн, хөрөнгийн нийт хуримтлал нэмэгдсэн нь бага ч гэсэн хувь нэмрээ оруулсан гэж АХБ-ны шинжээчид онцлов.

ОУВС-гийн хэрэгжүүлж буй "Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр"-ийн үр дүнд төсвийн алдагдал 2017 онд 15.3-аас 3.9 хувь болж буурсан. Өнгөрсөн онд төсвийн зарлага 5.7 хувь, орлого 35.4 хувиар нэмэгдсэн нь өөдрөг таамаглалд дэм болов. Мөн энэ онд дэлхийн зах зээл дээрх эрдэс баялгийн үнэ тогтвортой өсөх хандлагтай, уул уурхайн салбарт томоохон дэд бүтцийн төслүүд хэрэгжих хүлээлттэй байгаа нь улсын эдийн засгийг өөд татна хэмээн таамаглажээ. Хэрэв эдгээр төсөл үр дүнтэй хэрэгжвэл ДНБ-ий өсөлт АХБ-ны дээрх таамгаас ч давж болох юм.

Гэхдээ 2018 оны эцэст ДНБ-ий өсөлт 3.8 хувьд хүрэх таамаг нь 2017 оны 5.1 хувийн өсөлттэй харьцуулбал зөрүүтэй, уруудсан үзүүлэлт. Энэ онд улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй хэд хэдэн томоохон эрсдэл байгаа тул эдийн засгийн өсөлтийн эрч саарна гэж үзсэн байна. Үүнд экспортын орлогыг бүрдүүлж буй гол түүхий эдүүдийн үнэ буурах, ОУВС-гийн хөтөлбөрт саад учрах, "Оюутолгой"-н үйлдвэрлэл, хөрөнгө оруулалт тасалдах зэргийг дурджээ. Мөн махны үнэ өсөх, банкуудын бүтцийн өөрчлөлт хийх явцад санхүүгийн тогтвортой байдал алдагдах эрсдэл бийг анхааруулаа.

Монгол Улсын гадаад худалдаа, экспорт БНХАУ-аас ихээхэн хамааралтай.

- **Монгол Улсын ДНБ-ий өсөлт энэ онд 6.6 хувьд хүрэх хамгийн өөдрөг таамгийг BMI гаргажээ.**
- **БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2018 онд 6.6 хувь, 2019 онд 6.4 хувь болно.**
- **Азийн орнуудад АНУ-ын худалдааны протекционист бодлого болон бодлогын хүүгээ нэмэх гэж буйтай холбоотой эрсдэл бий.**

Тиймд эдийн засгийн төлөвийг гаргахад тус улсын нөхцөл байдлыг тооцохгүй өнгөрч болохгүй. Азийн хөгжлийн банкнаас тус улсын эдийн засаг 2018 онд 6.6 хувь, 2019 онд 6.4 хувиар өсөх төлөвийг танилцуулсан. Өнгөрсөн онд БНХАУ-ын үйлчилгээний салбар найман хувиар өссөн нь өмнөд хөршийн эдийн засгийн өсөлт үргэлжлэхэд шууд нөлөөлнө гэж үзжээ.

Харин бүс нутгаар авч үзвэл, Ази-Номхон далайн бүсийн ДНБ-ий өсөлт 2017 онд 6.1 хувьтай гарсан нь энэ онд зургаа, 2019 онд 5.9 хувь байхаар тооцсон байна. Түүнчлэн Төв Азийн орнуудын эдийн засгийн өсөлт 2018 онд дөрвөн хувь, 2019 онд 4.2 хувьтай гарна гэж үзэхдээ түүхий эдийн үнэ өсөх төлөвийг харгалзжээ. Номхон далайн орнуудын ДНБ ирэх хоёр жилд 2.2-3 хувиар өсөх таамаг байна. Гэхдээ Азийн орнуудад АНУ-ын худалдааны протекционист бодлого болон бодлогын хүүгээ түвшнээ нэмэх гэж буйтай холбоотой эрсдэл бийг шинжээчид онцолсон юм. [ЗГМ]




## ЗГМ ТОВЧХОН

**» ТАТВАР**

**68**

Мянган татвар төлөгч. Орон сууц, оюутны төлбөрийн буцаан олголтыг энэ сарын 20-ноос өгч эхэлнэ. Энэ онд улсын хэмжээнд нийт 68 мянган татвар төлөгч 40 гаруй тэрбум гаруй төгрөгийн буцаан олголт авахаар материалаа бүрдүүлэн өгчээ. Буцаан олголтыг ирэх сарын 15-ны дотор дуусгахаар төлөвлөсөн байна.

**» ТЭЭВЭР**

**6.1**

Сая тонн ачаа. "УБТЗ" ХНН өнгөрсөн оны байдлаар 6.1 сая тонн ачаа тээвэрлэжээ. Үүнээс 697 мянган тонн импортын ачаа тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 72.2 хувь өссөн дүн. Мөн 2.2 сая тонн экспортын ачаа тээвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 45 хувиар нэмэгджээ. Өнгөрсөн оны эхний улиралд манай улсын нутгаар дамжин өнгөрсөн транзит чингэлгийн галт тэрэгний тоо 62 байсан бол энэ оны эхний гурван сарын байдлаар 228-д хүрчээ.

**» ЭРЧИМ ХҮЧ**

**95**

МВт эрчим хүч. Дорноговь аймаг дахь 55 МВт-ын хүчин чадалтай Сайншандын салхин станцын бүтээн байгуулалтын ажил үргэлжилж байна. Уг станцын барилгын ажил энэ оны арваннэгдүгээр сард дуусах бөгөөд 30-40 хүнийг ажлын байраар хангаж, 100 мянган өрхөд эрчим хүч хүргэх юм. Энэ онд сэргээгдэх эрчим хүчний суурилагдсан хүчин чадал 95 МВт-аар нэмэгдхээр байна.

**» АВТО**

**1.6**

Тэрбум ам.доллар. БНХАУ-ын автомашин үйлдвэрлэгч Xiaopeng Motors компани энэ онд 1.6 тэрбум ам.долларын хөрөнгө босгохоор төлөвлөж байна. Тус компани Alibaba болон Foxconn Technology Group-ээс 2.2 тэрбум юанийн хөрөнгө оруулалт татаж байсан юм. Xiaopeng Motors компанийн анхны цахилгаан автомашин Crossover G3 энэ сарын сүүлээр худалдаанд гарна.

**» ХЭЛЦЭЛ**

Google компани Nokia-гийн нисэх онгоцны өргөн зурвасын сүлжээний бизнесийг худалдаж авах хэлэлцээ хийж байна. Хэлэлцээний дүнд Google компани нисэх онгоцны үйлчилгээнд ашиглаж байгаа Wi-Fi сүлжээний хурд, хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой болох аж. Google-ийн толгой компани болох Alphabet нь нисэх онгоцны өндөр хурдны интернет санал болгож хэрэглэгчдийнхээ тоог нэмэгдүүлэхийг зорьж буй.

## ВАЛЮТЫН ХАНШ

| | |
|---|---|
| АНУ-ын доллар | 2,392.76 |
| Евро | 2,961.40 |
| Японы иен | 22.36 |
| ОХУ-ын рубль | 37.50 |
| БНХАУ-ын юань | 380.83 |
| БНСУ-ын вон | 2.24 |

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

## Fitch агентлаг МАК-ийн зээлжих зэрэглэлийг баталгаажууллаа

**Э.Эрдэнэтуяа**
Шинжээч

Олон улсын зах зээлд бонд гаргахаар зэхэж буй МАК компанийн зээлжих зэрэглэлийг Fitch агентлаг "CCC+" түвшинд баталгаажууллаа. Тус компани бондоос босгосон хөрөнгөөрөө банкуудаас авсан зээлээ төлөхөөр төлөвлөж буй.

МАК компани бондын үндсэн нөхцөлд "Шинэ Нарийнсухайт"-ын нүүрсний орлого болон тусгай зөвшөөрлийг нэмэлт барьцаа хөрөнгө байдлаар тусгажээ. Үүний зэрэгцээ зээл олгогч байгууллагуудтай өрийн бүтцээ дахин шинэчлэх нөхцөлөө тохирсон байна. Fitch агентлаг өмнө нь мэдээлэхдээ МАК компани 200 сая ам.долларыг амжилттай босгож чадвал Европын сэргээн босголт хөгжлийн банк болон Германы хөрөнгө оруулалтын корпорациас авсан зээлээ бүрэн төлнө гэж мэдээлж байсан юм. Харин сүүлийн мэдээлэлд дурдсанаар бондын санхүүжилтийн 157.2 сая ам.долларыг дээрх хоёр байгууллагын зээлийн эргэн төлөлтөд зарцуулахаар төлөвлөж буйг дурджээ. Үүнээс гадна "Голомт" банкнаас авсан зээлийг бүтнээр нь, мөн Хөгжлийн банкны зээлийн тодорхой хэсгийг эргүүлэн төлөхөөр төлөвлөж байгааг онцоллоо.

**ОРОН СУУЦ**

## Компанийн хувь лизингийн үйлчилгээ нэмэгджээ

Ипотекийн зээлийн эрч саарсантай холбоотойгоор барилгын компаниуд орон сууцаа хувь лизингийн нөхцөлөөр худалдах нь нэмэгджээ. Нийслэлд хэрэгжиж буй 34.5 мянган айлын орон сууцны 110 төсөлд хийсэн судалгаагаар компаниудын 33 хувь нь дээрх нөхцөлөөр орон сууцаа борлуулж байгаа нь тогтоогджээ.

Энэ онд ипотекийн зээлд 300 тэрбум төгрөг төсөвлөсөн нь 5000 иргэнийг орон сууцаар хангахад л хүрэлцэнэ. Энэ нь худалдан авалтын эрэлтийг хангахгүй дүн гэдгийг салбарынхан онцолж буй. Компанийн хувь лизингийн нөхцөлийн хувьд урьдчилгаа 30-50 хувийг төлж, 1-2 жилийн хугацаатай хүүгүй авах, эсвэл 3-5 жилийн хугацаатай 8-12 хувийн хүүтэй авах нөхцөлийг барилгын компаниуд санал болгож байна.

"Барилга.мн"-ий дээрх судалгаанд баригдсан болон баригдаж байгаа төслүүдийг хамруулснаас 55 хувь нь зарагдаагүй болон захиалга авч байгаа орон сууц байгаа аж. Шинэ орон сууцны 110 төслийн хувьд ам метр талбайн дундаж үнэ Сонгинохайрхан дүүрэгт хамгийн хямд буюу 1.72 сая төгрөг, Сүхбаатар дүүрэгт хамгийн үнэтэй буюу 2.52 сая төгрөг байна. Дундаж үнийг 2017 оны мөн үеэтэй харьцуулахад Хан-Уул, Сүхбаатар дүүрэгт нэмэгджээ. Мөн найман хувийн зээлийн санхүүжилт багассантай холбоотойгоор эдгээр 110 төслийн 75 хувь нь зээлээр санхүүжих боломжгүй болжээ. Харин 16 хувь нь гэрээт банкаар дамжин зээлийн нөхцөл хангасан иргэдэд найман хувийн нөхцөлтэйгөөр борлуулж байна.

**ҮЙЛДВЭРЛЭЛ**

## "Анд Энерги"-ийн борлуулалт 24 хувиар өсөв

LED гэрлийн үйлдвэрлэл эрхэлдэг "Анд энерги" компанийн борлуулалт энэ оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 24 хувиар өссөн байна. Энэ хугацаанд нийт 5.5 мянган ширхэг LED гэрэл, гэрэлтүүлэг үйлдвэрлэж, 2.2 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулжээ. Тус компани оны эхний улиралд "Шарын гол", "Улаанбаатар төмөр зам" зэрэг томоохон компаниудтай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ хийжээ. Түүнчлэн Улаанбаатар хотод нэрийн дэлгүүрээ нээхээр төлөвлөж байгаа аж. Тус компанийн шинэ үйлдвэрийн барилга барих ажил энэ сарын эцсээр эхлэх юм.

Тус компанийн хөрөнгийн биржээр дээрх хувьцааны арилжааг харвал гуравдугаар сард нийт 39.4 сая төгрөгийн арилжаа хийгджээ. Энэ нь өмнөх сараас гурав дахин өндөр үзүүлэлт болсон байна. Мөн хувьцааных нь ханш 50 төгрөг болж он гарснаас хойших дээд цэгтээ хүрчээ.

## Эдийн засаг

**САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ**

С.Батсайхан / ЗГМ©

# Худалдааны дайныг эс тооцвол юанийн ханш тогтворжино

***Монгол Улсын импортын 13 хувийг юаниар хийдэг***

**Г.Байгал**
@baigalZGM

Манай улсын гадаад худалдааны гол хэрэгсэлд ам.долларын араас юань бичигдэж байна. Ялангуяа, Монголоос гадагш чиглэсэн худалдааны урсгал буюу импортын 70 хувийг ам.доллар, 13 хувийг юаниар хийдэг гэж төв банк мэдээлэв. 2017 оны байдлаар манай улсын нийт импорт 4.3 тэрбум ам.доллартай тэнцсэн гэж үзвэл монголчууд жилд дунджаар 560 орчим сая ам.доллартай тэнцэх юанийн санхүүжилтээр гадагш худалдан авалт хийдэг аж. Өөрөөр хэлбэл, нэг ам.доллар 6.2831 юаньтай (лхагва гарагийн байдлаар ) тэнцэж байгаа гэж үзвэл нийт 3.5 тэрбум юанийг импортод зарцуулдаг гэсэн тооцоо гарч байна. Энэ нь харьцангуй өссөн дүн болохыг төв банкны мэргэжилтнүүд онцолж байгаа юм. Сүүлийн жилүүдэд Монгол болон Хятадын төв банк юанийн своп хэлцэл хийж, хэмжээ болон хугацааг нь сунгасан. Мөн сүүлийн хоёр жилийг эс тооцвол Монголбанк юанийн интервенцийг идэвхтэй хийсэн нь импортод эзлэх урд хөршийн мөнгөн тэмдэгтийн хувь хэмжээг нэмэгдүүлжээ.

Хэдийгээр Монгол Улс урд хөрштэйгээ нийт гадаад худалдааныхаа 80 гаруй хувийг хийдэг ч дийлэнхийг нь ам.долларaар гүйцэтгэдэг. Төв банкны Судалгаа, статистикийн газрын мэдээлснээр Монгол Улс нүүрсний экспортоос юанийн орлого олж, үүнийгээ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортод зарцуулдаг байна. Сүүлийн жилүүдэд Монгол болон өмнөд хөршийн банк санхүүгийн байгууллагууд хооронд төлбөр тооцооны шинэ хэрэгсэл нэвтрүүлж, юанийн гүйлгээг улам хялбар болгосон. Тодруулбал, манай худалдаачид урд хөршийг зорихдоо төгрөгийг юань руу бэлнээр солиулах шаардлагагүй болж, Өвөр Монголын хотуудад өөрийн данснаасаа төгрөгийн санхүүжилтээ юаниар авах боломж бүрджээ.

Юанийн хэрэглээ ийн хялбаршиж байгаа нь юанийг дэлхийн валют болгох Ши Жиньпинийн бодлогын үр дүн. Хэрэглээний эдийн засагтай, үйлдвэрлэгч бус улсад гадаад валютын ханш онцгой чухал нөлөөтэй. Тэр тусмаа өмнөд хөршөөсөө худалдаа, эдийн засгийн хувьд үлэмж хамааралтай Монгол Улсад юанийн нөлөө чамгүй их.

Он гарсаар юанийн ханш тасралтгүй чангарч, өнгөрсөн хоёрдугаар сард түүхэн дээд цэг болох 384 нэгжийг шүргэсэн. Гэхдээ өнгөрсөн нэг сарын хугацаанд ялимгүй суларсан ч лхагва гарагийн байдлаар 380.83 нэгжид хэлбэлзэж байна. Өнгөрсөн оны гуравдугаар улирлаас энэ оны нэгдүгээр сар хүртэл юаньтай харьцах төгрөгийн ханш 3.5 хувиар суларчээ. Харин нэг жилийн хугацаанд 7.7 хувиар буурсан байна. Ингэснээр юань нь төгрөгийн эсрэг хамгийн огцом чангарсан гадаад валютад тооцогдов.

Тэгвэл эрчээ авч буй юанийн ханш цаашид хааш чиглэх бол. Өнөөг хүртэл энэ асуулт Монгол төдийгүй дэлхий нийтэд хариулт нэхсэн асуулт болчихоод байна. Учир нь дэлхийн худалдаанд дэндүү том байр суурь эзэлдэг АНУ, БНХАУ-ын хооронд худалдааны дайн дэгдэж эхэлсэн нь ам.доллар, юанийн ханшид тодорхойгүй байдал дагууллаа. Хоёр улсын хооронд үүссэн худалдааны саад тотгор цаашид хэрхэн өрнөхөөс хамаарч, эдгээр валютын ханш тодрохоор байна. Үүнээс үүдэн төгрөгтэй харьцах юанийн ханш богино хугацаанд хөдөлж магадгүй гэж шинжээчид үзэж байна.

- **Монгол Улс нүүрсний экспортоос юанийн орлого олж, үүнийгээ өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний импортод зарцуулдаг байна.**
- **Дэлхийн худалдаанд дэндүү том байр суурь эзэлдэг АНУ, БНХАУ-ын хооронд худалдааны дайн дэгдэж эхэлсэн нь ам.доллар, юанийн ханшид тодорхойгүй байдал дагууллаа.**
- **Юанийн ханшид нөлөөлдөг ам.долларын ханш төгрөгийн эсрэг өнгөрсөн оны есдүгээр сараас хойш тасралтгүй суларч буй төдийгүй цаашид тогтворжихоор байгаа аж.**

Үүнийг эс тооцвол төгрөгтэй харьцах юанийн ханш дунд хугацаанд тогтворжих хандлагатай байгаа гэж төв банк мэдээллээ. Хэдийгээр өдгөө юанийн ханш чанга хэвээр байгаа ч энэ нь түр зуурынх буюу улирлын шинж чанартай. Мөн монголчуудын уламжлалт баяраас үүдэлтэй өсөлт давамгайлжээ.

Үүнээс гадна юань нь ам.долларын ханшийг дагах хандлага ажиглагддаг. Гэтэл юанийн ханшид нөлөөлдөг ам.долларын ханш төгрөгийн эсрэг өнгөрсөн оны есдүгээр сараас хойш тасралтгүй суларч буй төдийгүй цаашид тогтворжихоор байгаа аж. Учир нь Монгол Улсыг чиглэх мөнгөний урсгал энэ онд нэмэгдэх дүр зураг бий. Тухайлбал, ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд энэ онд 860 гаруй сая ам.долларын санхүүжилт Монголыг чиглэнэ. Энэ оны дөрөвдүгээр сарын байдлаар үүний 100 гаруй сая ам.доллар нь манай улсад шилжсэн бөгөөд дахин 600-700 сая ам.долларын дотогшлох урсгал хүлээгдэж буй. Тэрчлэн алт болон нүүрсний орлого, "Оюутолгой"-н далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалт (улс төрийн нөлөөг тооцохгүйгээр) гэсэн шил шилээ дарсан санхүүлжилт хүлээгдэж байгаа нь манай улсын төлбөрийн тэнцэлд эергээр нөлөөлөх шалтгаан. Тэгвэл үүнийг даган юанийн ханш харьцангуй тогтвортой байх хандлагатай байна.

Энэ сарын байдлаар ам.долларын ханш юанийн эсрэг 0.5 хувиар чангараад байна. Гэхдээ Хятадын төв банк юанийн ханшийг ам.доллартай "уях" бодлого баримталсаар ирсэн. Юанийн ханш тогтвортой түвшинд хадгалагдаж байгаатай зэрэгцээд БНХАУ-ын гадаад валютын албан нөөц өссөөр байгаа юм. Тодруулбал, дэлхийд валютын нөөцөөрөө тэргүүлэгч тус улсын гадаад валютын албан нөөц 3.12 их наяд ам.доллартай тэнцэж байна. 2018 онд юанийн ханш ам.долларын эсрэг төдийлэн сулрахгүй гэж Францын Societe General банк таамаглажээ. [ЗГМ]

**Төгрөгтэй харьцах юанийн албан ханш**
(нэгжээр)




Монголбанк©

**Төгрөгийн голлох валюттай харьцах ханшийн өөрчлөлт**
(хувь)




Монголбанк©

**Ам.доллар, юанийн хослол**
(нэгжээр)




Bloomberg.com©

**БНХАУ, Монголын худалдааны эргэлт**
(сая ам.доллар)




Гаалийн ерөнхий газар©

## ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

**ГОВЬ ХК**




Өдөр ↑ -1.64% Сар ↓ Жил ↑

**АПУ ХК**




Өдөр ↓ -1.54% Сар ↓ Жил ↑

**МАХ ИМПЕКС ХК**




Өдөр ↓ 4.67% Сар ↑ Жил ↑

**СҮҮ ХК**




Өдөр ↓ -0.65% Сар ↑ Жил ↓

**Prophecy Development — Торонто**




Өдөр ↓ 1.89% Сар ↑ Жил ↓

**Rio Tinto — Лондон**




Өдөр ↓ 0.22% Сар ↑ Жил ↓

**Xanadu Mines — Австрали**




Өдөр ↓ -5.13% Сар ↓ Жил ↑

**Turquoise Hill Resources — Торонто**




Өдөр ↑ -4.59% Сар ↓ Жил ↓

| DOW JONES | S&P 500 | FTSE 100 | NIKKEI 225 | TOPIX | SHANGHAI COMPOSITE | HANG SENG | KOSPI |
|---|---|---|---|---|---|---|---|
| 0.34% | 0.49% | 0.14% | 0.49% | 0.38% | 0.56% | 0.55% | 0.27% |